

*Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны саналаар
хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан*

Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих чиглэлээр 2009 онд улсын төсвөөс олгосон хөрөнгийн зарцуулалт, зээлийн ашиглалт



**Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх, хөдөлмөр
эрхлэлтийг дэмжих чиглэлээр ажиллаж буй
сангуудын үйл ажиллагааг нэгдсэн
бодлогоор зохицуулах нь зүйтэй**

АГУУЛГА

Тайланг бэлтгэсэн:

ҮАГ-ын Гүйцэтгэлийн
аудитын газар

Захирал: Д.Ганбилэг

Аудитын менежер Х.Баярмаа

Шинжээч: Л.Эрдэнэчулуун

У.Баярмаа

2010 оны 3 дугаар сар

Уг тайланг ҮАГ-ын Веб сайт-аас
үзнэ үү.

www.mnao.pmis.gov.mn

Аудитын тайлан, дүгнэлттэй
холбоотой асуудлаар нэмж
тодруулах, асууж лавлах зүйл
байвал 261885 дугаарын утас,
323266 дугаарын факсаар
харилцана уу.

ХАЯГ:

Үндэсний аудитын газар

210642 Чингэлтэй дүүрэг,
Засгийн газрын 4 дүгээр байр,
Бага тойруу-6, Улаанбаатар-46
Монгол Улс

Товчилсон үгийн жагсаалт 3

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй 4

**Бүлэг 1. ЖДҮ-ийг дэмжих үйл ажиллагааг хэрэгжүүлэгч
байгууллагууд хуулийн заалтыг мөрдөөгүй байна**

Хөдөлмөр болон үйлдвэрлэл эрхлэлтийг дэмжих сангуудын
үйл ажиллагааны чиглэл хэт ерөнхий байна 6

ЖДҮХС төрийн өмчит улсын үйлдвэрийн газрын статустай
байгаа нь холбогдох хуультай нийцэхгүй байна 7

ЖДҮ эрхлэгчдийг хуулийн дагуу бүртгэлжүүлээгүй байна 8

Арилжааны банкуудыг тендерийн үндсэн дээр сонгон
шалгаруулаагүй байна 9

**Бүлэг 2. Төсөл сонгон шалгаруулах комиссын үйл
ажиллагаа, хяналт хангалтгүй байна**

Комиссын бүрэлдэхүүний сонголт оновчтой бус байна 10

Комиссын үйл ажиллагаа, сонгон шалгаруулалт шударга
явагдахгүй, явц, үр дүнг олон нийтэд мэдээлэхгүй байна 12

Хяналтын зөвлөл үүргээ биелүүлэхгүй байна 14

**Бүлэг 3. ЖДҮХСангийн үйл ажиллагаанд бүртгэлээр тавих
хяналт хангалтгүй байна**

Сангийн эх үүсвэрийг хуваарилах ажил 2009 оны сүүлийн
хагасаас эхэлж, зээл олголт оройтжээ 15

Эх үүсвэрийг бүрэн ашиглаагүй байна 17

Банкуудын зээл олгох үйл ажиллагаа удаашралтай байна 19

Зарим зээлдэгч зээлээ зориулалтын дагуу ашиглаагүй байна 19

Үр дүнгийн мэдээлэл зөрүүтэй байна 20

ЖДҮХС-гийн нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагнал,
бүртгэлээр тавих хяналт хангалтгүй байна 20

Аудитын дүгнэлт 22

Холбогдох байгууллагын санал 23

Саналд өгөх тайлбар 29

Зөвлөмж 31

Хавсралтууд 32

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

УИХ	<i>Улсын Их Хурал</i>
УАГ	<i>Үндэсний аудитын газар</i>
ХХААХҮС	<i>Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд</i>
ХХААЖДҮГ	<i>Хүнс, хөдөө аж ахуй, жижиг дунд үйлдвэрийн газар</i>
ХХААХҮЯ	<i>Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам</i>
ЖДҮГ	<i>Жижиг, дунд үйлдвэрийн газар</i>
ЖДҮ	<i>Жижиг дунд үйлдвэр</i>
ЖДҮТХ	<i>Жижиг, дунд үйлдвэрийн тухай хууль</i>
ЗДТГ	<i>Засаг даргын Тамгын газар</i>
МУХАУТ	<i>Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим</i>
ГССЗКЭ	<i>Гэмтэл согог сэргээн засах клиник эмнэлэг</i>

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, стандартын мэдэгдэл

Аудитыг Улсын Их Хурлын Төсвийн Байнгын хорооноос ирүүлсэн санал, Монгол Улсын Ерөнхий аудиторт Үндэсний аудитын газраас 2010 онд нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд хийв.

Аудитын зорилт

Жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх чиглэлээр улсын төсвөөс олгосон хөрөнгийн зарцуулалт, авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүнг үнэлж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдсэн.

Аудитын зорилтыг хангахын тулд дараахь чиглэлээр аудит хийлээ. Үүнд:

- Сангийн хөрөнгийн бүрдүүлэлт, хуваарилалт, төсөл сонгон шалгаруулалт;
- Зээлийн эх үүсвэрийн зарцуулалт, ашиглалт.

Хамарсан хүрээ

Аудитад ХХААХҮЯ, Жижиг, дунд үйлдвэрийн газар болон Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн 2009 оны үйл ажиллагаа, аймаг, нийслэлийн ЗДТГ-ын дэргэдэх ХХААЖДҮГ, Үйлдвэрлэлийн хэлтэс, дамжуулан зээлдүүлж буй Зоос, Хас, Капитрон, Монгол шуудан, Хадгаламж, Улаанбаатар, Худалдаа хөгжил, Голомт, Үндэсний хөрөнгө оруулалтын банк, тэдгээрийн орон нутаг дахь салбар нэгж, бусад холбогдох байгууллагыг хамруулав.

Арга зүй

Аудитыг гүйцэтгэхдээ Төрийн хяналт шалгалтын стандарт, түүнийг хэрэгжүүлэх аргачилсан зөвлөмж, гүйцэтгэлийн аудитын гарын авлага, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу дараахь арга зүйг ашиглав. Үүнд:

- Аудитад хамрагдсан байгууллагуудын холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, лавлагаа, тодруулга, зээлд хамрагдсан болон хамрагдаагүй бизнес эрхлэгчдээс санал асуулга авах;
- Хамрагдсан байгууллагуудын ажлын тайлан, төслийн сонгон шалгаруулалтын явц болон хөрөнгийн зарцуулалт, тайлагнал, цуглуулсан мэдээ, судалгаанд холбогдох асуудлаар дүн шинжилгээ хийх;

Энэхүү аудитыг гүйцэтгэх явц нь Аймаг, нийслэлийн аудитын газруудын 2009 оны санхүүгийн тайланг баталгаажуулах аудитын болон “Монголд үйлдвэрлэв 2010” үзэсгэлэн зохион байгуулсан үетэй давхардсанаас аудитын зарим горимыг хэрэгжүүлэхэд цаг хугацааны болон боловсон хүчний нөөц бүрэн ашиглагдаагүй болно.

Аудитын явцад зарим арилжааны банк мэдээллээ хугацаанд нь үнэн зөв гаргахгүй байх, ЖДҮ, бизнес эрхлэгчид санхүүгийн тайлан гаргаагүй, техник, тоног төхөөрөмжийг худалдан авсан анхан шатны баримтгүй, ашиглалтын талаар тайлбар, мэдээлэл өгөхөөс зайлсхийх, оршин суух болон үйлдвэрлэл, үйлчилгээ явуулж буй хаягандаа байхгүй зэрэг бэрхшээл учирч байлаа.

Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн шалгалтын журамд заасны дагуу аудитын дүн, дүгнэлтэд дэмжлэг болох нотлох зүйлс, холбогдох мэдээ судалгааг ажлын баримт материалд хавсаргав.

БҮЛЭГ 1. ЖДҮ-ийг дэмжих үйл ажиллагааг хэрэгжүүлэгч байгууллагууд хуулийн заалтыг мөрдөөгүй байна

1.1 2006 онд батлагдсан Засгийн газрын тусгай сангийн тухай хуулиар Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн үйл ажиллагаа зохицуулагдаж байна.

1.2 УИХ-ын 2008 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн “Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг батлах тухай” 43 дугаар тогтоолоор Жижиг, дунд үйлдвэрийн газар байгуулагджээ.

1.3 Дараахь хууль, тогтоолуудаар жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх үйл ажиллагаа зохицуулагдаж байна.

Эрх зүйн акт	Хууль, тогтоолын нэр	Батлагдсан огноо	Дугаар
МУ-ын хууль	Жижиг, дунд үйлдвэрийн тухай	2007	
	Жижиг, дунд үйлдвэрийн тоног төхөөрөмжийг гаалийн болон НӨАТ-аас чөлөөлөх тухай	2009	
УИХ-ын тогтоол	МУ-ын мянганы хөгжлийн бодлогод суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлого	2008	12
	МУ-ын Засгийн газрын 2008-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөр	2008	35
	МУ-ын эдийн засаг, нийгмийг 2009 онд хөгжүүлэх үндсэн чиглэл	2008	36
ЗГ-ын тогтоол	Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих хөтөлбөр	2005	64
	Орон нутагт үйлдвэрлэл хөгжүүлэх чиглэл	2009	178
	МУ-ыг үйлдвэржүүлэх хөтөлбөр 2009-2016 он	2009	299

1.4 ХХААХҮС-ын тушаалаар “Жижиг, дунд үйлдвэрийн газрын дүрэм”¹, “Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих сангийн дүрэм” болон “Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн хөрөнгө бүрдүүлэх, зарцуулах, түүнд хяналт тавих журам”-ыг² баталжээ.

1.5 ХХААХҮЯ-ны газар, хэлтсүүд, ЖДҮГ, ЖДҮХС, аймаг, нийслэлийн ЗДТГ-ын дэргэдэх холбогдох хэлтэс жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлж байна. ЖДҮ-тэй холбогдсон үйл ажиллагааны зорилт болон одоо ажиллаж буй орон тоог нэгж тус бүрээр үзүүлбэл:

ХХААХҮЯ-ны хэлтэс, агентлаг, сан	Жижиг, дунд үйлдвэрлэлтэй холбогдсон үйл ажиллагаа	Ажиллагсдын тоо
Хөнгөн үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар	ЖДҮ, жижиг бизнес хөгжих таатай орчинг бүрдүүлэх бодлогын хэрэгжилтийг зохицуулах,	9
Хүнсний үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар	ЖДҮ, жижиг бизнес хөгжих таатай орчинг бүрдүүлэх бодлогын хэрэгжилтийг зохицуулах,	9
Жижиг, дунд үйлдвэрийн газар	ЖДҮ-ийг эрчимтэй хөгжүүлж, өрсөлдөх чадварыг дээшлүүлж, үндэсний үйлвэрлэлийн өсөлтийг хангах, ДНБ-ний хэмжээг нэмэгдүүлэх, ажлын байр бий болгох зорилтын хүрээнд ЖДҮ-ийн хөгжлийг дэмжиж, эдийн засагт эзлэх байр суурийг бэхжүүлэх, хөгжлийн цаашдын чиг хандлагыг тодорхойлж, төрийн дэмжлэг үзүүлэх, тэдний эрх ашигт нийцсэн бизнесийн таатай орчныг бүрдүүлэх,	23
Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан	ЖДҮ, бизнес эрхлэгчдэд санхүүгийн дэмжлэг үзүүлж үйл ажиллагааг өргөжүүлж ажлын байр, тоног төхөөрөмжийг лизингээр олгох механизмийг бий болгох, зах зээлийн харилцаанд зохицсон сургалт зохион байгуулах замаар ЖДҮ, бизнес эрхлэгчдийн үйл ажиллагааны менежментийн чадавхийг сайжруулж зах зээлд өрсөлдөх чадварыг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх.	12
Нийт		53

¹ 2009 оны 1 дүгээр сарын 21-ний өдрийн 19 дүгээр тушаал

² 2009 оны 2 дугаар сарын 2-ны өдрийн 29 дүгээр тушаал

Хөдөлмөр болон үйлдвэрлэл эрхлэлтийг дэмжих сангуудын үйл ажиллагааны чиглэл хэт ерөнхий байна

1.6 ХЭДС, ЖДҮХС, ХОХС-гийн үйл ажиллагааны чиглэлийг харьцуулан үзүүлбэл:

Асуулт	Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	Хөрөнгө оруулалт хөгжлийн сан
Батлагдсан хууль, эрх зүйн актын огноо	Засгийн газрын тусгай сангийн тухай хууль 2006 он	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль 2001 он	Хөрөнгө оруулалт хөгжлийн сангийн хөрөнгийг захиран зарцуулах журам ЗГ-ын 2006 оны 258 дугаар тогтоол
Хуулийн дагуу сангийн хөрөнгийг зарцуулах үйл ажиллагааны чиглэл	14.5 Ажлын байр бий болгох, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэхэд зориулж урт хугацааны хөнгөлөлттэй зээл олгох, зээлийн баталгаа гаргах, мэргэжлийн зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах, сургалт, давтан сургалтад хамруулах, зарим төрлийн даатгалд хамруулах	10.1 Хувиараа болон өрхийн аж ахуй, эсхүл нөхөрлөл, хоршооны хэлбэрээр үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэхийг хүсэгч ... иргэн, түүнчлэн малчин, албан бус хөдөлмөр эрхлэгчдэд хөгжлийн бэрхшээлтэй иргэнд сангаас... аж ахуй эрхлэх ур чадвар эзэмшүүлэх сургалтад хамруулах, үйлдвэрлэл үйлчилгээ эхлэх болон шинээр ажлын байр бий болгох, өргөтгөхөд зориулан зээл олгох, бизнес инкубацийн үйлчилгээнд хамруулах, төсөл хөтөлбөр боловсруулахад арга зүйн зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах	4 бүлэг. Сангийн хөрөнгөөс улсын эдийн засгийн хөгжилд дорвитой хувь нэмэр оруулах тэргүүлэх ач холбогдол бүхий салбаруудад зээл олгож, зээлийн баталгаа гаргана. Үндэсний үйлдвэрийн бараа, бүтээгдэхүүнийг гадаад зах зээлд гаргахтай холбогдсон арга хэмжээг авах, үр ашигтай, ирээдүйтэй салбарын чиглэлээр бизнес инкубатор байгуулах үйл ажиллагааг дэмжиж санхүүжүүлнэ.
2009 онд зарцуулсан хөрөнгийн дүн (сая төгрөгөөр)	Сургалтын зардал-12,2 Олгосон зээл- 30,951.0	Зээл-9,050.0 Хүүгийн нөхөн төлбөр-106.0 Бизнес инкубацийн үйлчилгээ 382.2 Мэргэжил олгох давтан сургалтад- 2,188.7 Төсөл хөтөлбөр боловсруулахад арга зүйн зөвлөгөө өгөх- 239.1 Аж ахуй эрхлэлтийн сургалт- 594.3	Хөрөнгө оруулагчдын чуулга уулзалтын зардал-46.4

1.7 Дээрх 3 сангийн ажлын байр бий болгох, сургалт, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэхэд зориулж зээл олгох, бизнес үйлчилгээнд хамруулах, мэдээллээр хангах, зөвлөгөө өгөх зэрэг үйл ажиллагааны чиглэл давхардаж байна. Мөн ХХААХҮЯ-ны Тариалан эрхлэлтийг дэмжих сан, “Сүү” зэрэг хөтөлбөрүүд бизнес эрхлэгчдийг зээлд хамруулах үйл ажиллагаа явуулж байна.

1.8 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, үйлдвэрлэлийг хөгжүүлэх байгууллага, сангуудын үйл ажиллагаа тодорхой зааглагдаагүй, хэт ерөнхий чиглэлтэй, хоорондоо уялдаа холбоогүй байна.

1.9 Эдийн засгийн бүхий л салбар болон төсвийн ерөнхийлөн захирагчдын багцад жижиг, дунд үйлдвэрлэл, бизнес эрхлэгчдийг дэмжсэн төсөл, хөтөлбөр цөөнгүй байна.

1.10 Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэхдээ зөвхөн төсөл хүлээн авч сонгон шалгаруулж, зээл олгох бус тодорхой бодлого боловсруулан үе шатаар хэрэгжүүлэх нь зүйтэй байна. Хөгжлийн жишээ болохуйц зарим улс, орнуудад жижиг бизнесийг дараахь байдлаар³ хөгжүүлсэн байна.

БНСУ	БНХАУ	Япон улс
<i>БНСУ-ын жижиг дунд бизнесийг дэмжих тогтолцоог бизнес эрхлэгч нарын хувийн санаачлага дээр тулгуурлан төрийн бус байгууллага</i>	<i>Бизнес инкубацийн биеэ даасан өндөр чадавхитай бүтцийг бий болгож чадсан. Зээлийн баталгаа олгох, их, дээд</i>	<i>Сайн загвар буюу Япон улсын жижиг дунд бизнесийг дэмжих санхүүгийн үйлчилгээ, батлан даалт, даатгалын корпорацц,</i>

³ Эх сурвалж: Нийслэлийн жижиг дунд үйлдвэрийн төлөв байдал 2009 оны судалгааны материалаас,

нь төрийн үүргээ хэрэгжүүлдэг арга механизм бий болгож чадсан. Мөн жижиг бизнес эрхлэгчдийн бизнесийн орчинг хамгаалах, тусгай орчинг бий болгох, томхон ААН-ийн бизнесээс жижиг бизнест шилжүүлэх асуудлыг бодлогын хэмжээнд дэмждэг.

сургуулиудын дэргэд Бизнес инкубатор төвийг ажиллуулах, жижиг бизнес эрхлэгчдийг дэмжих сургалтын баазыг байгуулсан, залуучуудыг сургалтанд хамруулж, бүтцийн болон ШУ, технологийн дэвшилийг хэрэгжүүлж байна.

зээл дэмжих өргөтгөсөн систем, байгууллагуудыг бий болгосон. Санхүүгийн сахилгыг маш өндөрт тавьж хариуцлагыг бүрэн хүлээгээдэг.

Дээрх улс орнуудын бий болгосон системийн нийтлэг тал нь төрийн байгууллагуудын тунгалаг байдал, хариуцлагатай үйл ажиллагаа, ЖДҮ эрхлэгчдийн хамтач харилцаа, иргэдийн өөрсдийн идэвхитэй санаачлага, санхүүгийн эх үүсвэрийг зөвхөн шинэ санаа, шинэ технологи, шинэ материал түүхий эдийг эзэмших, оюуны багтаамж бүхий үйлдвэрлэл, үйлчилгээг явуулах, мэдээллийн технологийг түлхүү дэмжих, ашиглах, өндөр технологийн үйлдвэрүүдийг дэмжиж, өөрчлөлт, шинэтгэлийг удирдах, тогтвортой бизнесийг дэмжихэд чиглэгдэж байгаагийн зэрэгцээ бүх талын оролцогчдын ёс суртахуун, санхүүгийн сахилга бат, хариуцлагыг маш өндөрт тавьдаг байна.

ЖДҮХС төрийн өмчит улсын үйлдвэрийн газрын статустай байгаа нь холбогдох хуультай нийцэхгүй байна

1.11 ЖДҮХС нь УҮГ статустайгаар “Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх, дэмжих” чиглэлээр 2009 оны 3 дугаар сарын 11-ний өдрийн улсын бүртгэлийн 9070002081, регистрийн 5290082 дугаар бүхий гэрчилгээ авчээ.

1.12 Энэ нь Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 5.1-д “Засгийн газрын тодорхой чиг үүрэг, зорилтыг санхүүжүүлэх зорилгоор улсын нэгдсэн төсвөөс төвлөрүүлсэн хөрөнгө, түүнчлэн уг арга хэмжээнд зориулан олгосон хандив, буцалтгүй тусламжийн орлогыг Засгийн газрын “Тусгай сан” гэх”, Иргэний хуулийн 33.2-т ашгийн төлөө бус хуулийн этгээдийг холбоо, сан, хоршооны хэлбэрээр байгуулна гэж заасан. Гэвч “Улсын үйлдвэрийн газар” гэсэн статустай байгаа нь дээрх хуулийн заалттай зөрчилдөж байна.

1.13 “Засгийн газрын тусгай сангийн тухай” хуульд зааснаар ЖДҮХС-гийн зохион байгуулалт, орон тооны хязгаарыг Засгийн газар тогтоохоор заасан атал ХХААХҮС-ын тушаалаар⁴ тогтоож иржээ.

1.14 УИХ-ын 2007 оны 52 дугаар тогтоолын 1.2-т “Үйлдвэр, худалдааны яам болон холбогдох бусад төрийн захиргааны төв байгууллагын бүтцэд жижиг, дунд үйлдвэрийн чиглэлээр ажиллаж байгаа хэлтэс, алба, сан, төслийг жижиг, дунд үйлдвэрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын агентлагийн бүтцэд шилжүүлэх”-ээр заасан боловч ЖДҮХС нь ХХААХҮЯ-ны бүтцийн нэг нэгж хэлбэрээр үйл ажиллагаагаа явуулж байна.

1.15 Иргэний хуулийн 37.1-д “Сангийн эрх барих байгууллага буюу удирдах зөвлөл нь хандивлагч, дэмжигч, тэдгээрийн томилсон төлөөллөөс бүрдэнэ”, 37.2-т “Сангийн эрх барих байгууллага нь гүйцэтгэх удирдлага болон хяналтын байгууллагыг томилно” гэж заасан.

1.16 Харин Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд сангийн удирдах зөвлөл болон хяналтын байгууллагыг хэрхэн байгуулах талаар тодорхой заагаагүй байна.

1.17 ЖДҮХС-гийн дүрмээр сан нь ХХААХҮС-ын дэргэд улсын төсөв болон үйл ажиллагааныхаа орлогоос санхүүжин бие даасан хэлбэрээр ажиллах, мөн Удирдах

⁴ ХХААХҮС-ын 2009 оны 1, 49 дүгээр тушаал

зөвлөлтэй байхаар зохицуулсны дагуу 6 хүний бүрэлдэхүүнтэй ажиллаж байна. Харин хяналтын байгууллага байхгүй бөгөөд дүрмэндээ ҮАГ, МХЕГ хяналт тавихаар тусгажээ.

1.18 ЖДҮХС-гийн Удирдах зөвлөл⁵ 2009 онд 1 удаа хуралдаж, ЖДҮХС-гийн стратеги, бүтэц, зохион байгуулалтын хөтөлбөр, хөдөлмөрийн дотоод журам, цалингийн сүлжээ, төсвийн тодотгол зэрэг асуудлаар шийдвэр гаргажээ.

ЖДҮ эрхлэгчдийг хуулийн дагуу бүртгэлжүүлээгүй байна

1.19 ЖДҮТХуулийн 5 дугаар зүйлд⁶ тодорхойлсноор ЖДҮ эрхлэгчийн ангилал дараахь байдалтай байна.

Д.д	Ажиллагсдын тоо	Жилийн борлуулалтын орлого	ААН-ийн хэлбэр
1	Контракт, хөдөлмөрийн гэрээгээр 199-өөс дээшгүй	1.5 тэрбум төгрөг хүртэлх	Үйлдвэрлэл эрхэлдэг аж ахуйн нэгж, иргэн
2	Контракт, хөдөлмөрийн гэрээгээр 149-өөс дээшгүй	1.5 тэрбум төгрөг хүртэлх	Бөөний худалдаа эрхэлдэг аж ахуйн нэгж, иргэн
3	Контракт хөдөлмөрийн гэрээгээр 199-өөс дээшгүй	1.5 тэрбум төгрөг хүртэлх	Худалдаа эрхэлдэг аж ахуйн нэгж, иргэн
4	Контракт хөдөлмөрийн гэрээгээр 49-өөс дээшгүй	1 тэрбум төгрөг хүртэлх	Үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгж, иргэн
5	Контракт хөдөлмөрийн гэрээгээр 19-өөс дээшгүй	250 сая төгрөг хүртэлх	Үйлдвэрлэл эрхэлдэг аж ахуйн нэгж, иргэн
6	Контракт хөдөлмөрийн гэрээгээр 9-өөс дээшгүй	250 сая төгрөг хүртэлх	Худалдаа, үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгж, иргэн

1.20 Дээрх ЖДҮ эрхлэгчийн ангилалд томоохон аж ахуйн нэгжүүд багтан зээлд хамрагдаж байна.

1.21 ЖДҮТХуулийн 6 дугаар зүйлд⁷ жижиг, дунд үйлдвэрлэгчийн бүртгэл, тэмдэглэгээний талаар заасны дагуу Үндэсний татварын ерөнхий газар /хуучин нэрээр/-ын даргын 2008 оны 131 дүгээр тушаалаар жижиг, дунд үйлдвэрлэгчийн бүртгэлийн маягтуудыг баталсан ч улсын хэмжээнд нэг ч иргэн, хуулийн этгээд бүртгэлд бүртгэгдээгүй, иргэнд олгох гэрчилгээ хэвлэгдээгүй байна.

1.22 Үндэсний үйлдвэрлэлийг дэмжиж, импортыг орлох бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх, валютын нөөц, ажлын байрыг нэмэгдүүлэх, ЖДҮ эрхлэгч болон бизнес эрхлэгчдэд санхүү, хөрөнгө оруулалтын дэмжлэг үзүүлэх зорилгоор “ЖДҮ-ийн үйлдвэрлэлийн зориулалттай тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгслийг гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай” хуулийг 2009 оны 8 дугаар сарын 14-ний өдрөөс мөрдөхөөр, Засгийн газрын 2009 оны 10 дугаар сарын 14-ний 316 дугаар тогтоолоор уг хуулийн дагуу чөлөөлөгдөх зүйлсийн жагсаалтыг тус тус баталжээ.

1.23 2009 онд дээрх зориулалтаар 213 иргэн, аж ахуйн нэгж 1121.0 сая төгрөгийн гааль, НӨАТ-аас чөлөөлөгджээ. Үүнээс ЖДҮ-ийг хөгжүүлэх чиглэлээр зээлд хамрагдсан 30.2 сая төгрөгийн татвараас чөлөөлөгдсөн 9 аж ахуйн нэгж байна.

⁵ ХХААХҮС-ын 2009 оны 6 дугаар сарын 19-ний өдрийн 146 дугаар тушаал

⁶ Жижиг, дунд үйлдвэрийн тухай хуулийн 5 дугаар зүйл. Жижиг, дунд үйлдвэр эрхлэгч

⁷ Жижиг, дунд үйлдвэрийн тухай хуулийн 6 дугаар зүйл. Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчийн бүртгэл, тэмдэглэл

1.24 ЖДҮТХуулийн дагуу ЖДҮ эрхлэгч иргэн, аж ахуйн нэгжийг бүртгэлжүүлээгүйгээс чөлөөлөлтөд жижиг, дунд үйлдвэр эрхлэгчид хамрагдаж байгаа эсэх нь эргэлзээтэй байна.

Арилжааны банкуудыг тендерийн үндсэн дээр сонгон шалгаруулаагүй байна

1.25 ХХААХҮС-аас ЖДҮ эрхлэгчдийг дэмжиж олгох зээлийн эх үүсвэрийг арилжааны ХАС, Монгол шуудан, Зоос, Капитрон, Улаанбаатар, Худалдаа хөгжил, Голомт, Үндэсний хөрөнгө оруулалт, Хадгаламж, ХААН банкаар дамжуулан зээлдүүлэхээр “Хамтран ажиллах гэрээ”-г 2009 оны 6 дугаар сараас эхлэн байгуулжээ.

1.26 Ингэхдээ төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 3.1, 5.1.14, 6.1 дэх заалтуудыг мөрдөөгүй ХХААХҮС-ын баталсан журмаар⁸ зөвшиж сонгожээ.

1.27 ЖДҮХС-гийн дүрмийн 6.5-д “Сангийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээг холбогдох хууль тогтоомжийн дагуу сонгон шалгаруулалтын үндсэн дээр гүйцэтгэнэ” гэж заасан боловч сонгон шалгаруулалт хийгээгүй байна.

⁸ 1. ХХААХҮС-ын 2009 оны 2 дугаар сарын 2-ны өдрийн 29 дүгээр тушаал “Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн хөрөнгө бүрдүүлэх, зарцуулах, түүнд хяналт тавих журам”-ын “Сан нь гэрээ байгуулах банк болон банк бус санхүүгийн байгууллагыг Хөнгөн үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газартай зөвшиж сонгоно”,
2. ХХААХҮС-ын 2009 оны 6 дугаар сарын 19-ний өдрийн 147 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт “Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх чиглэлээр улсын төсвөөс олгох хөрөнгийг зарцуулах, түүнд хяналт тавих, тайлагнах заавар”-ын “Улсын төсвөөс Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зээлийг Хүнс, хөдөө аж ахуйн яамнаас байгуулсан “Төсөл сонгон шалгаруулах комисс”-ын хуралдааны шийдвэрийг үндэслэн Жижиг, дунд үйлдвэрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас сонгон шалгаруулж гэрээ байгуулсан арилжааны банкаар дамжуулан олгоно

Бүлэг 2. Төсөл сонгон шалгаруулах комиссын үйл ажиллагаа, хяналт хангалтгүй байна


Комиссын бүрэлдэхүүний сонголт оновчтой бус байна

2.1 ХХААХҮС-ын 2009 оны 5 дугаар сарын 8-ны өдрийн 107 дугаар тушаалаар “Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих зорилгоор арилжааны банкаар дамжуулан зээл олгох төслийг сонгон шалгаруулах комиссын үйл ажиллагааны журам”, 2009 оны 6 дугаар сарын 19-ний өдрийн 147 дугаар тушаалаар “Улсын төсвөөс гаргах хөрөнгийг жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдэд хөнгөлөлттэй зээлийн хэлбэрээр олгох ажлыг улсын хэмжээнд зохион байгуулах, зарцуулалтад хяналт тавьж ажиллах үүрэг бүхий төсөл шалгаруулах комиссын бүрэлдэхүүн”-ийг⁹ баталсны дагуу төсөл сонгон шалгаруулах комисс ирсэн төслүүдийг шалгаруулан арилжааны банкуудад хүргүүлж байна.

2.2 Аудитын явцад 21 аймаг, нийслэлд зээл авсан болон зээлд хамрагдаагүй 1600 гаруй иргэн, аж ахуйн нэгжээс 9 асуултаар санал асуулга авч дүнг нэгтгэн үзүүлэв. (Хавсралт №1)

2.3 Төсөл сонгон шалгаруулах комиссын /цаашид “Комисс” гэх/ бүрэлдэхүүн оновчтой сонгогдсон уу гэх асуулгад оролцогсдын 20 илүү хувь үгүй, 40 гаруй хувь нь мэдэхгүй гэж үзжээ.

“Төсөл сонгон шалгаруулах комиссын бүрэлдэхүүн оновчтой сонгогдсон уу” асуулгын дүн



2.4 Булган, Дорнод, Сүхбаатар, Сэлэнгэ, Ховд аймгийн комиссын бүрэлдэхүүнд банк, санхүүгийн байгууллагаас төлөөлөлгүй, цөөн аймагт ажил олгогч эздийн холбоо, Худалдаа, аж үйлдвэрийн танхимын орон нутаг дахь төлөөллийг эс тооцвол жижиг, дунд үйлдвэрийн чиглэлээр үйл ажиллагаа явуулах эрхтэй ажил мэргэжлийн холбоод, ТББ-ын төлөөлөл байхгүй, эдгээрийн төлөөллийг оролцуулахыг иргэдээс санал болгосон байна.

2.5 Комиссын үйл ажиллагааны журам болон банкуудтай байгуулсан гэрээний эрх үүргийн заалтын дагуу талууд үйл ажиллагаагаа зохистой хэлбэрээр уялдуулж ажиллахгүй байна. Тухайлбал:

- Архангай аймаг хамтран ажиллах гэрээг банкттай байгуулаагүй, комиссын үйл ажиллагааны журмын 4.1-т заасны дагуу зээл олголт, эргэн төлөлтийн талаарх мэдээ тайланг тухайн цаг хугацаанд нь гаргах болон дэд комиссоос банкинд хүргүүлсэн төслийн санхүүжилтийн талаар дэлгэрэнгүй мэдээ, судалгааг тухай бүр гаргуулж хэвшээгүй, тухайн төсөлд зээл олгоогүй шалтгаан, дараагийн төсөл шалгаруулалтад анхаарах асуудлыг харилцан ойлголцож нэг байр суурь, бодлого баримтлаагүй, харилцан мэдээлэл солилцдоггүй нь иргэд, аж ахуйн нэгжид чирэгдэл учруулдаг байна.
- Дорноговь аймаг хамтран ажиллах гэрээг банкттай байгуулаагүй, “зээл олголт, эргэн төлөлтийн байдалд мониторинг, үнэлгээ хийж ажлын тайланг ЖДҮХС-д хүргүүлж байна” гэсэн журмын заалтыг Засаг даргын дэргэдэх зөвлөл мөрдөж ажиллаагүй байна.
- Увс аймаг дахь банкнаас 30.0 сая төгрөгийн зээл комиссын шийдвэргүйгээр олгосон байна.

⁹ ХХААХҮС-ын 2009 оны 5 дугаар сарын 8-ны өдрийн 107 дугаар тушаал

- Мөн аймгийн комисс дэмжсэн хэдий ч банкны шалгуурт тохируулсан гэсэн үндэслэлээр нохойн арьс боловсруулах үйлдвэрийн 30.0 сая төгрөгийн зээл нь гутал засварын зориулалтаар 20.0 сая төгрөгийн зээл болсон, төмөр тор нэхэх үйлдвэр байгуулах 10.0 сая төгрөгийн төсөл дэмжигдсэн ч автозасвар, жимс жимсгэнэ тариалах, худаг гаргах 10.0 сая төгрөгийн төсөл түүхий эд худалдан авах цэг, эсгийний үйлдвэр барих 10.0 сая төгрөгийн төсөл газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэх, үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж авах 15.0 сая төгрөгийн төсөл хүнсний дэлгүүр ажиллуулах чиглэлээр болж зээлийн зориулалт нь өөрчлөгдсөн байна.
- Ховд аймаг хамтран ажиллах гэрээг банктай байгуулаагүй байна. Комиссын шийдвэрийн дүнг өөрчилж 6 төслийн зээлийн дүнг 57.5 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 10 төслийн 59.5 сая төгрөгийг комиссын шийдвэрэгүй зөвхөн албан бичгийг үндэслэн олгосон байна.
- Төв аймаг дахь комиссын 2009 оны 9 дүгээр сарын 12-ны өдрийн хуралдаанаар дэмжигдсэн төсөл банкны зээлийн судалгаанд хамрагдаж явсаар ондоо багтаж олгогдоогүй байна.

2.6 Банкнаас буцаагдсан төсөл, чөлөөлөгдсөн буюу төлөгдсөн зээл, ашиглагдаагүй эх үүсвэр, шалгараагүй төслийг үнэлж сонгон шалгаруулалтыг дахин явуулж зээл олгох зэргээр орон нутагт үйлдвэрлэл хөгжүүлэх чиглэлээр хуваарилагдсан хөрөнгийн ашиглалтыг сайжруулах боломж байжээ.

2.7 Санал асуулгаар оролцогсдын 60.9 хувь зээл олгох шалгуур үзүүлэлт бодит байдалд нийцэхгүй, өөрчлөх шаардлагатай гэж үзсэн байна.



2.8 Дэмжигдсэн зарим төсөл зээлийн барьцаа хөрөнгөгүй, банкны шалгуурт нийцээгүй, бусад хэлбэрээр зээлтэй, төслийн болон санхүүгийн баримтын бүрдүүлэлт дутуу, зээлийн зориулалт төслийн шаардлага хангахгүй, үр ашгийн тооцоо муу зэрэг шалтгаанаар зээл олгогдоогүй, түүнчлэн зарим сумдад тухайн банкны салбар, нэгж

байхгүйгээс төсөл шалгараагүй байна.

- Баян-Өлгий аймагт нийт 124 төслийг комиссоос шалгаруулан харилцагч банкинд зээл олгохыг зөвшөөрснөөс 41 нь шалгуур үзүүлэлтийг хангаагүй,
- Дорноговь аймгийн комиссоос 166 төслийг хүргүүлснээс 61 төсөлд зээл олгож үлдсэн 105 төслөөс 47-г дахин судлах, 57 төсөл буцаагдсаны эзэн нь ирж уулзаагүй 24, өөрсдөө татгалзсан 4, барьцаа хөрөнгө, зээлийн шаардлага хангаагүй 32, эх үүсвэрэгүй гэсэн шалтгаанаар 45 төсөл зээлд хамрагдаагүй,
- Орхон аймагт 97 төслийг дэмжин банкинд уламжилснаас 51 төсөл зээлийн шаардлага хангаагүй,
- Өвөрхангай аймагт банкнаас буцаагдсан төслүүдийн 81.2 хувь барьцаа хөрөнгө хангалтгүй, 6.3 хувь материалаа бүрдүүлж өгөөгүй, 65 төсөл тухайн үйлдвэрлэлийг 1-ээс доошгүй жил эрхэлсэн туршлагатай байх шаардлагыг хангаагүй буцсан,
- Төв аймгийн комиссын шалгаруулсан 148 төслөөс 44 төсөл банкны шалгуур хангаагүй шалтгаанаар хасагдсан,
- Увс аймгийн комисст нийт ирсэн төслийн 86.2 хувийг дэмжиж банкинд шилжүүлсний 84.0 хувь зээлд хамрагдсан,
- Баян-Өлгий, Баянхонгор, Төв, Өмнөговь аймгийн комисс ирсэн төслийн 46.6-71.0 хувийг дэмжсэний 80.5-100.0 хувь нь банкнаас зээл авсан.
- Бусад аймгуудын комисст ирсэн төслийн 37.0-78.8 хувийг дэмжсэний 34.6-68.8 хувь зээлд хамрагджээ.

2.9 Орон нутагт үйлдвэрлэл хөгжүүлэх чиглэлээр дамжуулан зээл олгож буй арилжааны 9 банкны холбогдох албан тушаалтан, зээлийн мэргэжилтнүүдтэй

хийсэн ярилцлага, Монгол шуудан, Худалдаа хөгжил, Голомт зэрэг банкны ҮАГ-т ирүүлсэн тайлбарт комиссын үйл ажиллагаа, комиссын болон арилжааны банкны зээлийн шалгуур үзүүлэлтийг ойртуулах, сонгон шалгаруулалтыг нээлттэй, шуурхай явуулах, арилжааны банк төвлөрүүлсэн эх үүсвэрийг бүрэн дайчилж ажиллах шаардлагатай байгааг дурдсан байна.

Комиссын үйл ажиллагаа, сонгон шалгаруулалт шударга явагдахгүй, үр дүнг олон нийтэд мэдээлэхгүй байна

2.10 Төслийн сонгон шалгаруулалт болон зээл олголтын судалгаа, мэдээллээс үзэхэд сонгон шалгаруулалтыг бодитой хийгээгүй, дэмжигдсэн зарим төсөл, үйлдвэрлэл хөгжүүлэх чиглэлд зориулагдаагүй, шударга бус өрсөлдөөнийг бий болгосон, хуулиар тодорхойлогдсон¹⁰ жижиг, дунд үйлдвэр эрхлэгч иргэн, аж ахуйн нэгж хамрагдаж чадаагүй тохиолдол гарсан байна. Тухайлбал:

а. Төсөл сонгон шалгаруулах комиссын сонгон шалгаруулалт шударга бус байсан;

- Архангай аймагт “Амьжиргаа” төсөл 30.0 сая төгрөгөөр дэмжигдсэн нь комиссын хурлын тэмдэглэл болон Засаг даргын захирамжийн хавсралтаар батлагдаж байгаа боловч банкинд очсон материалд байхгүй, банкнаас зээлдэгчийн нэр өөрчлөгдөн, зочид буудал, зоогийн газрын зориулалтаар 30.0 сая төгрөгийн зээл олгогдсон байна.
- Сүхбаатар аймгийн комиссын анхны хуралдаанаар төмс, хүнсний ногоо, бут суулгах 6 төслийг тариалалтын хугацаа хэтэрсэн шалтгаанаар хассан боловч 3 дахь хуралдаанаар “Усалгаатай хүнсний ногоо тариалах” төслийг “Малын тэжээл үйлдвэрлэх” нэрээр оруулж зээл олгуулсан нь дэд комиссын төслийн сонгон шалгаруулалт шударга явагдаагүйг илтгэж байна.
- Төв аймгийн комиссын гишүүдийн 100 хувийн саналаар бодлогын зээлд хамруулан зээл олгох нь зүйтэй гэж шийдвэрлэн Хөгжлийн бодлогын хэлтэст даалгав гэснээс өөр баримтгүйгээр тус аймгийн харъяат бус иргэнд 50.0 сая төгрөгийн зээл Хас банкаар дамжуулан олгосон.
- Мөн аймагт “Хурга бойжуулах” 10.0 сая төгрөгийн, “Фермер” 8,0 сая төгрөгийн зэрэг 9 төсөл өөр хуулийн этгээдийн нэртэй байжээ.
- Дорноговь аймагт комиссын үйл ажиллагааны журмын заалтыг зөрчин аймаг, сумын төрийн байгууллагад ажилладаг албан хаагчдын ирүүлсэн төслийг хэлэлцэн баталж байжээ.
- Орхон аймаг дахь комиссын гишүүдийн зээлийн төсөлд үнэлгээ хийсэн, санал өгсөн баримт байхгүй, хурлын протоколд тэмдэглээгүй, иргэн, аж ахуйн нэгжээс ирүүлсэн төслийн бүртгэл хангалтгүй, хуралдааны тэмдэглэл үйлдээгүй, шалгаруулсан төслийн үнэлгээ, тооцоо судалгаагүй, шийдвэр гаргасан гэх боловч баримтжуулаагүй, сонгон шалгаруулсан баримтгүй атлаа зарим төсөл шийдвэргүйгээр банкинд иржээ.

в. Жижиг, дунд үйлдвэр хөгжүүлэх чиглэл, зорилтод нийцээгүй төслийг сонгон шалгаруулсан;

- Орон нутагт үйлдвэрлэл хөгжүүлэх чиглэлийн хүрээнд олгох эх үүсвэрээс Улаанбаатар хотод Зочид буудлын үйлчилгээг дэмжиж 250.0 сая төгрөг,
- Увс аймагт кафе, зоогийн газар ажиллуулахад 45.0 сая төгрөг,
- Фото тоног төхөөрөмж авах зориулалтаар 20.0 сая төгрөг,
- Дорноговь аймагт мал борлуулах төсөлд 8.0 сая төгрөг,
- Архангай аймагт бөөний худалдаа эрхлэх чиглэлээр 5.0 сая төгрөг, мөн худалдаа үйлчилгээний зориулалтаар 25.0 сая төгрөг,
- Төв аймгийн Зуунмод суманд блок үйлдвэрлэх цех олон байхад энэ чиглэлээр 3 төсөлд бүгд 20.0 сая төгрөгийн зээл олгожээ.
- Улаанбаатар банкттай байгуулсан гэрээгээр бодлогын гэгдэх зээл нийт эх үүсвэрийн 10.0 хувиас хэтрэхгүй байхаар заасан ч 1 зээлдэгчид олгох зээлийн хэмжээний талаар гэрээнд заагаагүй атлаа зээлийн эрсдэлийг ЖДҮХС 100 хувь хариуцахаар байна.
- Мөн нийслэлд “Цахилгаан тээвэр” ТӨҮГ 110.0 сая төгрөгийг их, урсгал засварт зориулан зээл авсан байна.

¹⁰ Жижиг, дунд үйлдвэрийн тухай хуулийн Хоёрдугаар бүлэг, 5 дугаар зүйл


г. Үйлдвэр байгуулах хүсэлт ирүүлсэн төслийн зээл дэмжигдээгүй, хөрөнгийн хуваарилалт оновчтой бус байна;

- Архангай аймагт “Малын тэжээл, хадлан бэлтгэх”-д 35.0 сая төгрөгийн хүсэлтэд 3.0 сая төгрөг,
- Ариун цэврийн цаасны үйлдвэр байгуулах 41.3 сая төгрөгийн төсөлд 12.0 сая төгрөг,
- Шахмал түлш хийх 50.0 сая төгрөгийн төсөлд 7.6 сая төгрөг,
- Сав баглаа боодлын үйлдвэр байгуулах 50.0 сая төгрөгийн төсөлд 10.0 сая төгрөг
- Дорноговь аймагт “ХАА-н тоног төхөөрөмж үйлдвэрлэх” 20.0 төгрөгийн төсөлд 10.0 сая төгрөг,
- Увс аймагт барилгын материал үйлдвэрлэх 50.0 сая төгрөгийн хүсэлтэд 10.0 сая төгрөг,
- Төв аймагт Хаягдал хуванцар хайлуулж эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх 30.0 сая төгрөгийн зээлийн хүсэлтэд 10.0 сая төгрөгийн зээл олгогдсон бөгөөд зориулалтын дагуу ашиглаагүй, үйл ажиллагаагаа эхлээгүй,
- Мөн аймагт “Оёдол” төслийн 25.0 сая төгрөгийн хүсэлтэд 10.0 сая төгрөгийн зээл олгосон ч хүрэлцэхгүй шалтгаанаар үйл ажиллагаагаа явуулаагүй байна.

2.11 Түүнчлэн зээлийн эх үүсвэрээс давсан хэмжээний санхүүжилт шаардагдах төслийг шалгаруулан арилжааны банкинд шилжүүлсэн байна.


- Дорноговь аймгийн комиссоос 2009 онд нийт 2.4 тэрбум төгрөгийн 166 төслийг шалгаруулж арилжааны банкинд шилжүүлсэн.
- Дорнод аймагт 1879.5 сая төгрөгийн 121 төслийг банкинд хүргүүлсэн.
- Орхон аймгийн комисс нь орон нутаг дахь төвлөрүүлсэн эх үүсвэрээс 2.8 дахин илүү буюу 2159.5 сая төгрөгийн эх үүсвэр шаардсан 97 төслийг шалгаруулан банкинд шилжүүлсэн.
- Ховд аймгийн комиссын шийдвэрээр 1.1 тэрбум төгрөгийн 119 төслийг банкинд хүргүүлж байжээ.
- Гэтэл Нийслэлийн комисс ирсэн төслийг 100 хувь банкинд шилжүүлсний 28.1 хувь зээлд хамрагдсан бөгөөд төсөлд үнэлгээ дүгнэлт өгч зохих ёсоор сонгон шалгаруулалт хийгээгүй байна.

Төслийн сонгон шалгаруулалтыг шударгаар явуулж чаддаг уу? асуулгын дүн



2.12 Төслийн сонгон шалгаруулалт шударга явагддаг уу? гэсэн асуултад оролцогсдын 34.6 хувь “үгүй”, 34.3 хувь “зарим талаар” гэж хариулжээ.

Комиссын үйл ажиллагаа олон нийтэд нээлттэй байж чаддаг уу? асуулгын дүн



2.13 Засгийн газраас баталсан орон нутагт үйлдвэрлэл хөгжүүлэх чиглэл, олгож буй зээлийн талаар комиссоос сурталчлаагүй, буцаагдсан төслийн шалтгааныг олон нийтэд мэдээлэх ажлыг хангалтгүй хийж байна.

2.14 Санал асуулгад оролцогсдын 72.5 хувь комиссын үйл ажиллагаа олон нийтэд нээлттэй ажилладаггүй, мэдэхгүй гэж үзсэн байна.

Хяналтын зөвлөл үүргээ биелүүлэхгүй байна

2.15 Комиссын үйл ажиллагаа хангалтгүй байгаа нь хяналтын зөвлөлийн ажилтай ч холбоотой байна. Хяналтын зөвлөл 10 аймагт байгуулагдсан бөгөөд зарим аймгийн хяналтын зөвлөл зохих үүргээ хэрэгжүүлээгүй, зээл олголт, эргэн төлөлтийн байдалд мониторинг, үнэлгээ хийж тайланг¹¹ ЖДҮХС-д ирүүлээгүй байна.

2.16 Төв аймгийн Засаг дарга комиссын даргаар өөрийгөө томилж, хяналтын зөвлөлийн гишүүн нь комиссын хуралдаанд асуудлыг танилцуулан тэмдэглэл хөтөлж төсөл сонгон шалгаруулах журмыг зөрчсөн, Баян-Өлгий аймгийн Санхүү, төрийн сангийн мэргэжилтэн комисс болон хяналтын зөвлөлийн гишүүнээр давхар томилогдсон байна.

¹¹ ХХААХҮС-ын 2009 оны 5 дугаар сарын 18-ны өдрийн “Комисс шинэчлэн байгуулах, журам батлах тухай” 107 дугаар тушаал,

Бүлэг 3. ЖДҮХСангийн үйл ажиллагаанд бүртгэлээр тавих хяналт хангалтгүй байна

Сангийн эх үүсвэрийг хуваарилах ажил 2009 оны сүүлийн хагасаас эхэлснээс зээл олголт оройтжээ

3.1 2009 онд Улсын төсвөөс ЖДҮ эрхлэгчдийг дэмжих чиглэлээр олгох зээлийн эх үүсвэрт ХХААХҮС-ын багцад 850.0 сая төгрөг тусгагдсан бөгөөд 2009 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиар¹² Хөдөлмөр, ажил эрхлэлт, ЖДҮ дэмжих чиглэлээр өгөх тусламж, дэмжлэгт 30.0 тэрбум төгрөг нэмж баталсан болон 2006 онд арилжааны банкуудад байршуулсан зээлийн эх үүсвэрийн 1.0 тэрбум төгрөгийг дахин хуваарилахаар шийдвэрлэсэнтэй нийлээд нийт 31850.0 сая төгрөг төсөвлөсөн байна.

3.2 Засгийн газрын 2008-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан зорилтыг хэрэгжүүлэх, 2009 оныг “Үйлдвэржилтийг дэмжих жил” болгон зарласан болон “Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих хөтөлбөр”-ийн 3.3.2 дахь заалтыг үндэслэн 30.0 тэрбум төгрөгийн эх үүсвэрийг¹³ жижиг, дунд үйлдвэрийг дэмжих дэд сангуудад хуваарилсан бөгөөд үүнд аймаг бүрт 500.0 сая, нийслэлд 7.0 тэрбум, бүгд 17.5 тэрбум, орон нутагт үйлдвэр хөгжүүлэх, эдийн засгийн хөгжилд нөлөө үзүүлэхүйц арга хэмжээг санхүүжүүлэх эх үүсвэрт 12.5 тэрбум төгрөг хуваарилагджээ. Төсөвлөсөн эх үүсвэрийн хуваарилалт, бүрдэлтийг үзүүлбэл:

Хүснэгт №1

жижиг, дунд үйлдвэр дэмжих чиглэлээр улсын төсвөөс олгосон хөрөнгийн хуваарилалт

/сая төг/

Банкны нэр	Бүрдүүлэх эх үүсвэр					Эх үүсвэрийн бүрдэлт					Олгосон зээлийн хэмжээ
	ЖДҮХС	2006 оны эх үүсвэр	Орон нутгийн төсөв	Банк 30%	Нийт	ЖДҮХС	2006 оны эх үүсвэр	Орон нутгийн төсөв	Банк 30%	Нийт	
1. ЖДҮ хөгжүүлэх дэд сангуудад хуваарилсан хөрөнгө											
Хас	4 300,0	340,0	290,0	1 479,0	6 409,0	4 200,0	340,0	374,9	1 473,9	6 388,8	6 454,9
МШ	3 760,0	330,0	260,0	1 305,0	5 655,0	3 760,0	330,0	335,0	1 327,5	5 752,5	5 731,9
Төрийн	3 290,0	290,0	230,0	1 143,0	4 953,0	3 390,0	290,0	161,0	1 152,3	4 993,3	4 647,4
Улаанбаатар	5 000,0			1 500,0	6 500,0	5 000,0			1 500,0	6 500,0	6 266,6
Капитрон	2 000,0	40,0	50,0	627,0	2 627,0	2 000,0	40,0	25,0	619,5	2 684,5	2 688,5
Дүн	18.350,0	1000,0	830,0	6 054,0	26 144,0	18.350,0	1000,0	895,9	6 073,2	26.319,1	25.789,3
2. Орон нутагт үйлдвэрлэл хөгжүүлэх чиглэлээр батлагдсан хөрөнгийн хуваарилалт											
ХХБ	2 880,0	-	-	-	2 880,0	2 880,0	-	-	528,0	3 408,0	3 254,5
ҮХО-ын	2 800,0	-	-	-	2 800,0	2 800,0	-	-	112,1	2 912,1	772,1
Хадгаламж	2 240,0	-	-	-	2 240,0	2 240,0	-	-	80,0	2 320,0	687,0
Голомт	1 736,0	-	-	-	1 736,0	1 736,0	-	-	214,0	1 950,0	1 140,0
Капитрон	804,0	-	-	-	804,0	600,0	-	-	-	600,0	388,5
Улаанбаатар	160,0	-	-	-	160,0	160,0	-	-	40,0	200,0	200,0
ХААН	320,0	-	-	-	320,0	320,0	-	-	80,0	400,0	400,0
МШ	760,0	-	-	-	760,0	760,0	-	-	120,0	880,0	600,0
Төрийн банк	800,0	-	-	-	800,0	800,0	-	-	-	800,0	120,0
Дүн	12.500,0	-	-	-	12 500,0	12.296,0	-	-	1 174,1	13.470,1	7 562,1
Нийт дүн	30.850,0	1000,0	830,0	6 054,0	38 644,0	30.646,0	1000,0	895,9	7 247,3	39.789,2	33.351,4

¹² Монгол Улсын Их Хурлын 2009 оны 3 дугаар сарын 13-ны өдрийн хуралдаанаар баталсан

¹³ Сангийн сайд, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын хамтарсан 2009 оны 6 дугаар сарын 9-ны өдрийн 132/137 дугаар тушаал

3.3 Гэрээний дагуу Хас, Монгол шуудан, Зоос, Улаанбаатар, Капитрон банкуудад эх үүсвэрийг 2009 оны 7 дугаар сарын 1-нээс 14-нд шилжүүлсэн бөгөөд зээл олголтын судалгаагаар Хас банкны Дархан-Уул, Өвөрхангай, Хэнтий аймаг дахь салбар 8 дугаар сарын 11-нээс 28-нд, Монгол шуудан банкны салбарууд 8 дугаар сарын 13-наас 21-нд, Зоос банкны Архангай, Дорнод, Сэлэнгэ, Хөвсгөл аймаг дахь салбарууд 8 дугаар сарын 13-наас 26-нд, Улаанбаатар банк 8 дугаар сарын 18-наас зээл олгож эхэлжээ.

3.4 Эх үүсвэрийг тусгай зориулалтын сангийн дансанд байршуулснаас хойш ажлын 25-42 хоногт Хас, Монгол шуудан, Зоос, Улаанбаатар банкнаас зээл олгогдоогүй байна.

3.5 Нийт зээлийн 74.3 хувийг 7-9 дүгээр сард, 25.0 хувийг 10-12 дугаар сард олгожээ.

3.6 ХХААХҮС-аас банкуудтай Хамтран ажиллах болон нэмэлт гэрээг 2-оос 3 хүртэлх жилийн хугацаатай байгуулсан бөгөөд зээл эргэн төлөгдөх хугацаа дунджаар 2.4 жил байна. (Хавсралт №2)

3.7 Хас банкинд эх үүсвэр шилжүүлэхээс өмнө 3-6 сард 267.2 сая төгрөгийн зээл олгосон ба 2009 онд шилжүүлсэн эх үүсвэрээс олгосноор ташаа тайлагнасан байна.

3.8 Зарим аймаг орон нутгийн төсвийн дэмжлэгийг гэрээний дагуу төвлөрүүлээгүй байна. Тухайлбал,

- Баян-Өлгий аймагт орон нутгийн төсвийн дэмжлэг 14.0 сая төгрөгөөр дутуу,
- Булган аймагт 2006 оны хөнгөлттэй нөхцөлөөр олгосон зээлийн эргэн төлөлтөөс 8.0, ХАС банк 4.5 бүгд 12.5 сая төгрөгөөр дутуу,
- Өвөрхангай аймаг орон нутгийн эх үүсвэрийн 30.0 сая төгрөгийг тусгай зориулалтын санд 9 дүгээр сард төвлөрүүлсэн,
- Сэлэнгэ аймаг 30.0 сая төгрөгийг төвлөрүүлээгүй.

3.9 Дэмжигдсэн төслийн нэр, зориулалт өөрчлөгдөж зээл олгосон байна.

- Дорноговь аймагт “Эсгийний үйлдвэр” гэж дэмжигдсэн ч Фото студийн зориулалтаар 10.0 сая төгрөг олгосон,
 - “Сүүний үйлдвэр” төслийн зээлийн зориулалт нь хуванцар эдлэл үйлдвэрлэх 10.0 сая төгрөг,
 - “Авто засвар” гэсэн төслийн зээлийн зориулалт угаалгын төхөөрөмж, машин угаалгын 7.0 сая төгрөг,
- Дорнод аймагт “Цаасан уут” гэсэн төсөлд канон компьютер, жааз үйлдвэрлэх зориулалтаар 27.0 сая төгрөг,
 - “Амтат талх” төслөөр хүнс, барааны дэлгүүр ажиллуулахад 10.0 сая төгрөг,
- Өвөрхангай аймагт: Хархорин төсөлд эргэлтийн хөрөнгө нэмэгдүүлэх, тоног төхөөрөмж авахад 50.0 сая төгрөг,
- Архангай аймагт: “Талх нарийн боов” нэртэй төслийн зээлийн зориулалт “Мах, сүүний үхэр өсгөх” 25.0 сая төгрөг болж өөрчлөгдсөн байна.

3.10 Түүнчлэн зарим банк дэмжигдсэн төслийн хэмжээнээс илүү зээл олгосон байна.

- Өвөрхангай аймагт “Тоосгоны үйлдвэр” төслийн 20.0 сая төгрөгийн санхүүжилтийн хүсэлтэд үйлдвэрээ өргөтгөхөд 30.0 сая төгрөг,
- “Өв санаа” төслийн 30.0 сая төгрөгийн хүсэлтэд үйлдвэрээ өргөтгөхөд 35.0 сая төгрөг,
- Архангай аймагт “Оёдол” төслийн 15.0 сая төгрөгийн санхүүжилтийн хүсэлтэд 20.0 сая төгрөг,


- Орхон аймгийн комиссын шийдвэрээр ахуйн үйлчилгээний чиглэлээр дэмжигдсэн 10.0 сая төгрөгийн төсөлд банкнаас сүүний чиглэлийн ферм байгуулах зориулалтаар 13.0 сая төгрөг тус тус олгосон байна.

3.11 2009 онд аймаг, нийслэлийн комисст 89.5 тэрбум төгрөгийн төсөл ирсний 45.9 хувь буюу 41.2 тэрбум төгрөгийн төсөл дэмжигдсэнээс 62.6 хувь буюу 25.7 тэрбум төгрөгийн зээлийг банкууд олгосон нь анх ирүүлсэн төслийн 28.8 хувийг эзэлж байгаа бөгөөд оны эцсийн байдлаар 796.6 сая төгрөгийн зээл төлөгджээ.

Зээлийн хэмжээ	Зээлдэгчийн тоо, Үүнээс			Олгосон зээл
	бүгд	ААН	Иргэн	
150.0 мян.төг хүртэл	1		1	150 000
1.0-3.0 сая төгрөг	257	2	255	572 921 810
3.0-5.0 сая төгрөг	309	4	305	1 449 501 811
5.0-10.0 сая төгрөг	443	28	415	3 921 404 523
10.0-20.0 сая төгрөг	276	89	187	4 757 815 564
20.0-30.0 сая төгрөг	117	54	63	3 192 758 424
30.0-40.0 сая төгрөг	53	29	24	1 988 100 000
40.0-50.0 сая төгрөг	130	94	36	6 394 700 000
50.0-70.0 сая төгрөг	2	-	2	125 000 000
70.0-100.0 сая төгрөг	4	4		347 000 000
100.0-300.0 сая төгрөг	11	11		2 540 000 000
500.0 сая төгрөг	1	1		500 000 000
Нийт	1 604	316	1 288	25 789 352 132

3.12 Олгосон зээлд дүн шинжилгээ хийж үзэхэд зээлдэгч иргэдэд 3.0-10.0 сая төгрөг хүртэлх, аж ахуйн нэгжид 10.0-20.0 болон 40.0-50.0 сая төгрөгийн зээл эрэлттэй байжээ.

Зээлийн хэмжээ /сая төг/



3.13 Нийт олгосон зээлийн 62.5 хувийг хөдөө орон нутагт, 37.5 хувийг нийслэлд, 20.4 хувийг хөнгөн үйлдвэрийн, 17.6 хувийг үйлчилгээний, 15.6 хувийг хүнсний үйлдвэрлэлийн, 14.3 хувийг мал аж ахуйн, 7.5 хувийг барилгын, 6.0 хувийг газар тариалангийн, 18.6 хувийг бусад салбар тус тус эзэлж байна.

Эх үүсвэрийг бүрэн ашиглаагүй байна

3.14 Орон нутагт үйлдвэрлэл хөгжүүлэх чиглэлийн хүрээнд эдийн засгийн хөгжилд нөлөө үзүүлэхүйц арга хэмжээг санхүүжүүлэхээр банкинд байршуулсан эх үүсвэрийг бүрэн ашигласан гэж тайлагнасан боловч 2009 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар тусгай зориулалтын санд байршуулсан эх үүсвэрээс 6388.0 сая төгрөгийн зээл олгож, эх үүсвэрийн 47.8 хувь үлдэгдэлтэй байна.

Банкны нэр	Банкинд байршсан эх үүсвэр	Олгосон зээлийн хэмжээ		
		Сангийн Эх үүсвэр	Арилжааны Банк	Үлдэгдэл
Голомт банк	1 680.0	926.0	214.0	1 140.0
ХААН	320.0	320.0	80.0	400.0
Монгол шуудан	760.0	1087.0	200.0	600.0
Хадгаламж	2 240.0		-	687.0
ҮХО-ын	2 800.0	660.0	112.1	772.1
Улаанбаатар	160.0	160.0	40.0	200.0
ХХБанк	2 880.0	2726.5	528.0	2 998.5
Капитрон	600.0	388.5	-	388.5
Зоос	800.0	120.0	-	120.0
Дүн	12 240.0	6 388.0	1 174.1	7 162.1

3.15 Нийт олгосон зээлийн 34.3-36.3 хувь Сэлэнгэ аймаг болон нийслэлийн дүүргүүдэд байршиж байна.



3.16 ХХААХҮС-ын 2009 оны 147 дугаар тушаалаар батлагдсан комисс орон нутагт үйлдвэр хөгжүүлэх чиглэл, эдийн засгийн хөгжилд нөлөө үзүүлэхүйц арга хэмжээг санхүүжүүлэх зорилтын хүрээнд 3 удаагийн хуралдаанаар 78.4 тэрбум төгрөгийн 65 төслийн 64.6 хувийг дэмжсэн байна.

3.17 Комиссын дэмжсэн зээлийг судлан үзэхэд 10 төсөлд анх хүссэн дүнгийн 16.2-40.0 хувиар, 32 төсөлд 42.0-100.0 хувиар тус тус зээл олгохоор шийдвэрлэжээ.

3.18 Дээрх тушаалаар батлагдсан журмын 5.2.11-д нийт санхүүжилтийн 40-өөс доошгүй хувийг өөрийн эх үүсвэрээр санхүүжүүлэх шаардлага хангасан байхаар заасан боловч шалгаруулсан төсөл энэ шаардлагыг хангасан эсэх, түүнчлэн олгосон зээл үр дүнтэй ашиглагдаж, үйл ажиллагаанд бүрэн дэмжлэг болсон нь тодорхойгүй байна. Орон нутагт үйлдвэр хөгжүүлэх чиглэлийн хүрээнд олгосон зээлийн дэлгэрэнгүй судалгааг хавсралт №3-аар үзүүлэв.

3.19 Монгол банкны “Иргэд, жижиг дунд үйлдвэр эрхлэгч аж ахуйн нэгжид олгосон зээлийн 2009 оны тайлан”-гаас үзэхэд багагүй хэмжээний эх үүсвэр ашиглагдаж байна.

Хүснэгт №4

ЖДҮ эрхлэгч иргэд, аж ахуйн нэгжид олгосон зээлийн 2009 оны тайлан /мян.төг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Тайлант улиралд		Эцсийн үлдэгдэл	
		Олгосон зээл	Төлөгдсөн зээл		
2009 оны 1 улирал	ЖДҮ эрхлэгч иргэд	291 658 791,5	27 968 048,4	64 512 914,5	263 528 256,4
	ЖДҮ эрхлэгч ААН	212 927 450,3	20 680 562,3	36 992 755,9	201 896 595,8
2009 оны 2 улирал	ЖДҮ эрхлэгч иргэд	263 528 256,5	65 364 718,2	80 143 626,9	247 303 738,1
	ЖДҮ эрхлэгч ААН	201 896 595,8	37 158 715,0	29 492 074,2	206 087 755,4
2009 оны 3 улирал	ЖДҮ эрхлэгч иргэд	247 303 738,0	81 298 853,7	67 294 602,0	271 227 667,9
	ЖДҮ эрхлэгч ААН	206 357 763,7	49 961 442,1	32 503 790,3	221 972 266,8
2009 оны 4 улирал	ЖДҮ эрхлэгч иргэд	271 227 668,0	75 518 165,6	87 639 316,1	255 636 884,1
	ЖДҮ эрхлэгч ААН	221 972 266,8	45 951 191,6	46 301 799,8	227 430 818,2
Дүн		403 901 696,9	444 880 879,7		

Эх сурвалж: Монголбанк Гадаадын зээл, буцалтгүй тусламжаар олгогдсон зээлийн дүн ороогүй

3.20 ЖДҮ, бизнес эрхлэгчдэд төсөл бичих талаар анхан шатны мэдлэг олгох сургалт хийгдээгүйгээс төсөл бэлтгэх тухай ойлголтгүй, банк барьцаа хөрөнгийг зах зээлийн үнээс доогуур үнэлдгээс шалтгаалан үйлдвэрлэгчид боломжит зээлийг авч чадахгүй байна.

Банкуудын зээл олгох үйл ажиллагаа удаашралтай байна

3.21 Санал асуулгад оролцогсдын 75.6 хувь нь банкны зээл олгох үйл ажиллагаанд сэтгэл дундуур байна.

3.22 Банкууд зээл эргэн төлөгдөх эрсдэлийн судалгаа хийж, төслийг давтан шалгаж байгаа нь зээл олголтыг удаашруулж байна.



голлон бэрхшээл гардаг гэж үзжээ.



3.23 Түүнчлэн чанаргүй зээлтэй, өөр банкинд зээлийн үлдэгдэлтэй, барьцаа хөрөнгө хангалтгүй, бизнесийн үйл ажиллагаа нь тогтворжоогүй, төсөл хэрэгжүүлэх, үйлдвэрлэл эрхлэх бэлтгэл ажил хангагдаагүй гэсэн шалтгаан ч нөлөөлж байна.

3.24 Судалгаанд хамрагдагсдын 64.0 хувь зээл авахад арилжааны банкинд

Зарим зээлдэгч зээлээ зориулалтын дагуу ашиглаагүй байна

3.25 ХХААХҮЯ-ны орон нутагт зээлийн ашиглалтыг шалгасан ажлын хэсгээс ЖДҮ эрхлэхээр зээл авсан нийт зээлдэгчийн 80 орчим хувь зээлийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулж байна гэж дүгнэжээ.¹⁴

3.26 Зарим зээлдэгч тухайн зээлийг зориулалт бусаар ашигласан байна. Тухайлбал:

- Архангай аймагт шалгалтад хамрагдсан 35 зээлдэгчийн 23 хувь буюу 124.6 сая төгрөгийн, 17.2 хувь буюу 130.0 сая төгрөгийн зээлийн 30-50 хувь зориулалт бусаар ашиглагдсан,
- Дорноговь аймагт талх нарийн боов хийх 12.0 сая төгрөгийн, хөлдөөсөн бууз банш үйлдвэрлэх 50.0 сая төгрөгийн төслүүд огт хэрэгжээгүй буюу зээлийг зориулалт бусаар ашигласан,
- Сүхбаатар аймагт барилгын материал үйлдвэрлэхээр 40.0 сая төгрөгийн зээл авсан ч үйл ажиллагаа нь тодорхойгүй, өөр банкны зээлийн төлбөрт 15.3 сая төгрөгийг төлсөн,
 - Бодлогын зээлээр сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэх 10.0 сая төгрөгийн төсөл дэмжигдсэн боловч зориулалт өөрчлөгдөн нарийн боовны цех болсон.
 - Цагаан идээ боловсруулах 15.0 сая төгрөг, оёдол, фермерийн аж ахуй эрхлэх 18.0 сая төгрөгийн төслийн зээлээр хувийн байшин барьсан.
- Төв аймагт модон эдлэлийн үйлдвэрлэл эрхлэх 10.0 сая төгрөгийн зээл авсан ч орон нутагт зах зээлгүй гэсэн шалтгаанаар нийслэлд үйл ажиллагаа явуулдаг,
 - Ажлын хувцас үйлдвэрлэх, тоног төхөөрөмж авах, түүхий эд материал бэлтгэх 10.0 сая төгрөгийн төслийн хэрэгжилт мөн зах зээлгүй гэдэг шалтгаанаар нийслэлд байдаг,
 - Үрлэн чихэр үйлдвэрлэх 5.0 сая төгрөгийн, керамикийн зүйлс үйлдвэрлэх 5.0 сая төгрөгийн зээл аваад тодорхой хийсэн зүйлгүй, талх нарийн боовны "Аргал хайрхан

¹⁴ Эх сурвалж: 2009 онд ЖДҮ-ийг дэмжих чиглэлээр олгосон 30.0 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлийн хэрэгжилтийн талаархи танилцуулга, ЖДҮГ

төсөл"-өөр 6.0 сая төгрөгийн зээл авсан ч хувийн өрөндөө өгсөн, Өнгөлгөөний замаск үйлдвэрлэх төслийн 10.0 сая төгрөгийн зээлдэгч үйл ажиллагаагаа эхлээгүй байна.

- Увс аймгийн төвд үнээний ферм байгуулахаар бүгд 40.0 сая төгрөгийн зээл авсан 4 зээлдэгч хөрөнгийг зориулалт бусаар ашиглажээ.
- Орхон аймагт сүүний фермийн 8.0 сая төгрөгийн төслийн зээлээр гахай худалдан авсан байна.

3.27 Нийт зээлийн 32.2 хувь буюу 10.7 тэрбум төгрөгийг 4 дүгээр улиралд олгосон бөгөөд улирлын чанартай бизнес эрхэлдэг, зээл аваад удаагүй зэрэг шалтгаанаас зээлийн ашиглалт, үр дүнд үнэлэлт, дүгнэлт өгөх боломж муу байна.

Үр дүнгийн мэдээлэл зөрүүтэй байна

3.28 ЖДҮГ-гаас гаргасан мэдээгээр¹⁵ нийт 7733 ажлын байр шинээр нэмэгдэхээр байсан бол ЖДҮХС-гийн мэдээгээр¹⁶ 5255 ажлын байр нэмэгдсэн гэж тайлагнасан байна.

3.29 Шинээр бий болсон ажлын байр Баян-Өлгий аймагт ЖДҮХС-гийн мэдээгээр 150 байхад аймгийн аудитын газраас ирүүлсэн тайлангаар 211-ээр илүү, Дорноговь аймагт 57 гэсэн нь 30-аар, Орхон аймагт 56 гэсэн нь 27-оор, Сүхбаатар аймагт 236 гэсэн нь 145-аар, Сэлэнгэ аймагт 158 гэсэн 96-аар дутуу байжээ.

3.30 Нийслэлд зохион байгуулагдсан “Монголд үйлдвэрлэв 2010” үндэсний үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний үзэсгэлэнд оролцогчдоос ЖДҮ, орон нутагт үйлдвэр хөгжүүлэх чиглэл, эдийн засгийн хөгжилд нөлөө үзүүлэхүйц арга хэмжээг санхүүжүүлэх зээлд 7 аж ахуйн нэгж хамрагдсан байна.

ЖДҮХС-гийн нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагнал, бүртгэлээр тавих хяналт хангалтгүй байна

3.31 ЖДҮХС 2009 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар арилжааны 5 банкны 6 харилцах дансанд 1145.5 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Д.д	Банк	Дансны дугаар	2009.12.31-ний Үлдэгдэл
1	Капитрон	3003002466	3 312 282.71
2	Капитрон	3053003697	1 140 850 048.34
3	Улаанбаатар	2611009267	9 433.41
4	ХХБ	453011405	245 347.73
5	Монгол шуудан		1 097 516.42
6	ХААН		
	Дүн		1 145 514 628.61

3.32 ХХААХҮС-ын тушаалаар¹⁷ баталсан “Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн дүрэм”-ийн 1.6-д

“... Төрийн сан болон арилжааны банкинд харилцах данстай байна” гэсэн нь Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 32.2¹⁸, Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн 14.1.2 дахь¹⁹ заалтыг зөрчиж байна.

3.33 НББ-ийн тухай хууль, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан “НББ-ийн дансны заавар”-ын 4.13-ыг зөрчин арилжааны банкуудтай хяналтын зардлын тооцоог хийж баталгаажуулан бүртгэлд тусгаагүй, бүрэн төвлөрүүлж аваагүй байна.

¹⁵ Төслийн сонгон шалгаруулалтын явцын мэдээ 2009 он, ЖДҮГ

¹⁶ ЖДҮХС-гийн төслийн зээлийн санхүүжилтийн талаарх мэдээлэл, 2010 оны 1 дүгээр сарын 26

¹⁷ 2009 оны 2 дугаар сарын 2-ны өдрийн 29 дүгээр тушаал

¹⁸ “... тусгай сангийн дансыг төрийн сангаас гадуур байршуулахыг хориглоно”

¹⁹ “Улсын төсвийн байгууллага мөнгөн хөрөнгийн нэгдсэн зохицуулалтаас гадуур данс нээхийг хориглоно”

3.34 ҮХЯ-ны /хуучин нэрээр/ дансаар авлагын бүртгэлтэй байсан 2006-2008 онд ЖДҮ-ийг дэмжих чиглэлээр Хадгаламж, Зоос, Монгол шуудан банкинд байршуулсан 2970.0 сая төгрөгийн зээлийн эх үүсвэрийг яамдын бүтцийн өөрчлөлтийн дагуу ХХААХҮЯ бүртгэлд авалгүй орхигдуулсан байна.

3.35 ЖДҮХС-гийн 2009 оны санхүүгийн тайланд тусгагдсан 2.3 сая төгрөгийн авлага, 88.9 сая төгрөгийн өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй, оны эхэнд байсан 1120.3 сая төгрөгийн авлагыг шийдвэрлэх шаардлагатай байна.

3.36 ЖДҮХС-гаас санхүүгийн болон архивын програм хангамж худалдан авсан боловч ашиглаагүй, анхан шатны баримтын бүрдэлт, НББ-ийн хөтлөлт, хөрөнгөд бүртгэлээр тавих хяналт муу, мэдээ, тайлан бодитой илэрхийлэгдээгүй байлаа.

Аудитын дүгнэлт:

- Хөдөлмөр, ажил эрхлэлт, жижиг, дунд үйлдвэрийг дэмжих, үйлдвэрлэлийг хөгжүүлэх чиглэлээр үйл ажиллагааг хэрэгжүүлж буй Засгийн газрын тусгай сангууд, төсөл, хөтөлбөрүүдийн үйл ажиллагааны чиглэл давхардсан, уялдаа холбоо муутай байна.
- ЖДҮХС УУГ-ын статустай байгаа нь Иргэний хуулийн 33.2, Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 5.1 дэх заалттай нийцэхгүй байна
- ЖДҮТХуулийн 6 дугаар зүйлд заасны дагуу бүртгүүлээгүй ЖДҮ эрхлэгч иргэн, аж ахуйн нэгж зээлд хамрагдсан байна.
- ЖДҮ эрхлэгчдэд олгох зээлийг дамжуулан зээлдүүлэх арилжааны банкуудыг тендерийн үндсэн дээр сонгон шалгаруулаагүй байна.
- Төсөл сонгон шалгаруулах комиссын бүрэлдэхүүн оновчтой бус, сонгон шалгаруулсан зарим төсөл ЖДҮ-ийг хөгжүүлэх үндсэн чиглэл, зорилтод нийцээгүй, үр дүнг олон нийтэд мэдээлээгүй, хяналтын зөвлөл үүргээ хэрэгжүүлээгүй байна.
- Санхүүгийн эх үүсвэрийн хуваарилалт хугацаа алдсан, банкны зээл олгох үйл ажиллагааны горимоос шалтгаалан зээл олголт удааширсан, улирлын чанартай бизнес эрхэлдэг, зээл аваад удаагүй зэрэг шалтгаанаас зээлийн ашиглалт, үр дүнд үнэлэлт, дүгнэлт өгөх боломж муу байна.
- Эх үүсвэрийн бүрдүүлэлт, хуваарилалт, ашиглалт, зээл олголтын болон үр дүнгийн тайлан, мэдээ үнэн зөв гарч тайлагнагдахгүй байна.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас ирүүлсэн санал:



**МОНГОЛ УЛСЫН
ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ,
ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН
ЯАМ**

13381 Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг,
Энхтайваны өргөн чөлөө 16а, Засгийн газрын IX байр,
Утас: 26-22-71, Факс: (976-11) 45-25-54,
E-mail: mofa@mofa.gov.mn; http://www.mofa.gov.mn

2010.06.29 № 1/920
танай _____-ны № _____-т

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОРЫН ОРЛОГЧ Б.БАТБАЯР
ТАНАА

Санал хүргүүлэх тухай

Үндэсний аудитын газраас “Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих чиглэлээр 2009 онд улсын төсвөөс олгосон хөрөнгийн зарцуулалт”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлантай танилцаж, холбогдох саналыг хүргүүлэв.

Хавсралт: 5 хуудас.

ТӨРИЙН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА



Т.ГАНТУЛГА

0801263

Хавсралт

Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих чиглэлээр
2009 онд улсын төсвөөс олгосон хөрөнгийн
зарцуулалт, зээлийн ашиглалтад
Үндэсний аудитын газраас хийсэн
үнэлгээний тайлбар

Нэгдүгээр бүлэг:

1.11, 1.12 хүрээнд:

Тайлбар: ЖДҮХСан нь 2009 онд Үндэсний татварын ерөнхий газрын Улсын бүртгэлийн албанд бүртгүүлж Улсын бүртгэлийн гэрчилгээ авахад тус газрын мэргэжилтэн нь Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн дагуу байгуулагдсан сангуудын нэгэн адил “Төрийн байгууллага, албан газар, улсын төсөвт үйлдвэрийн газар” нэршлээр гэрчилгээ олгосон нь хууль зөрчөөгүй болно. Иргэний хуулийн 33.2-т заасан “сан” гэсэн ойлголт нь төрийн байгууллагын хувьд нийцэхгүй ба төрийн бус байгууллага байгуулахад мөрдөгдөх заалт гэдгийг Улсын бүртгэлийн албаныхан албан ёсоор тайлбарлаж өгсөн.

Санал: Энэ заалтыг хасах саналтай байна. Учир нь: бусад адил төстэй үйл ажиллагаа явуулдаг сангууд нь мөн адил Статустай байгаа нь ингэж дүгнэхэд учир дутагдалтай юм.

1.14 хүрээнд:

Тайлбар: Монгол Улсын Их Хурлаас 2006 онд батлагдсан “Засгийн газрын тусгай сангийн тухай” хуулийн 5.4.6 дахь хэсэг, 14 дүгээр зүйлүүдэд жижиг, дунд үйлдвэрийг дэмжих үйл ажиллагаанд шаардагдах хөрөнгийг санхүүжүүлэх зорилго бүхий “Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан” гэж байхаар хуульчлан баталгаажуулж өгсөн. 2007 онд батлагдсан “Жижиг, дунд үйлдвэрийн тухай” хуулийн 22 дэх зүйлийн 22.1-д “Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих үйл ажиллагаанд шаардагдах хөрөнгийг санхүүжүүлэх зорилго бүхий Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан байна”, 22.2-д “Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх санг бүрдүүлэх, зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах, хянахтай холбогдсон харилцааг Засгийн газрын тусгай сангийн тухай хуулиар зохицуулна” гэж тодорхой зааж өгсөн.

Улсын Их Хурлын 43 дугаар тогтоолыг 2008 онд шинэчлэн баталсан бөгөөд энэ тогтоолоор Улсын Их Хурлын 14 дүгээр тогтоолыг хүчингүй болгосон. Улсын Их Хурлын 2004 оны 14 дүгээр тогтоол хүчингүй болсонтой холбогдуулан Улсын Их Хурлын 2007 оны 51,52 дугаар тогтоолын үйлчлэх хүрээ хязгаарлагдсан.

Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан нь Засгийн газрын тогтоолоор орон тоо бүтцээ батлуулж байгаагүй бөгөөд зөвхөн жижиг, дунд үйлдвэрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрээр байгуулагдан нэгтгэх, бие даалгах үйл явц явагдаж ирсэн.

Тайлбар 1-ийг
үзнэ үү.

Тайлбар 2-ыг үзнэ үү.

Санал: Улсын Их Хурлын 43 дугаар тогтоолыг 2008 онд шинэчлэн баталсан бөгөөд энэ тогтоолоор Улсын Их Хурлын 14 дүгээр тогтоолыг хүчингүй болгосноор Улсын Их Хурлын 2007 оны 51,52 дугаар тогтоолын үйлчлэх хүрээ хязгаарлагдсан.

1.26 хүрээнд:

Тайлбар: Бүх шалгуур үзүүлэлтүүдэд сайн байсан гэх Анод, Зоос банкууд нь гэнэт дампуурч байсан нь банкныг тендерээр бус туршлага, байгууллагын ил тод байдал, зээлийн багцын чанар, Монгол банкны шалгуур үзүүлэлтүүдийг хангасан байдал зэргийг харгалзан сонгох нь илүү гэдэг нь бодит амьдрал дээр харагдаж байна.

“Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн хүрээнд банкуудыг сонгон шалгуурлахад олон хүндрэлтэй талууд байна. Үүнд: Хэд хэдэн оролцогчийг сонгож авах боломж хязгаарлагдмал, цаг хугацаа алдах магадлал өндөр, учир дутагдалтай ба зээл олголтод хүндрэлтэй байдал үүсгэдэг.

Тайлбар 3-ыг үзнэ үү.

Санал: Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2009 оны 107 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих зорилгоор арилжааны банкаар дамжуулан хөнгөлөлттэй зээл олгох төслийг сонгон шалгаруулах дэд комиссын үйл ажиллагааны журам”-ын 1.11-ийн дагуу банкуудтай гэрээ байгуулж ажиллахаар тусгаж өгсөн. Үүний дагуу өмнөх онуудад хамтран ажиллаж ирсэн арилжааны банкуудтай хамтран ажиллах боломжтой гэж үзэж хамтран ажиллах гэрээ байгуулж зээлийг дамжуулан зээлдүүлэх ажлыг зохион байгуулжээ.

Хоёрдугаар бүлэг:

“Төсөл сонгон шалгаруулах комиссын үйл ажиллагаа хяналтгүй байна”
гарчигийн агуулгын хувьд:

Тайлбар: - ХХААХҮЯ, ЖДҮГ, ЖДҮХС-аас 2009 онд бүх аймгуудад 2 удаа томилолтоор ажиллаж Дэд комиссын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж ажилласан.

Санал: “Төсөл сонгон шалгаруулах комиссын үйл ажиллагаа хяналт хангалтгүй байна” гэж өөрчлөх.

Тайлбар 4-ийг үзнэ үү.

“Комиссын бүрэлдэхүүний сонголт оновчтой бус байна” – гарчигийн агуулгын хувьд:

Тайлбар: Комиссын бүрэлдэхүүний сонголт аймаг бүрт харилцан адилгүй байсныг өөрчилж шинэ журмаар зохицуулж албан тушаалаар, байгууллагын төлөөллийг нэр зааж оруулж өгсөн.

Тайлбар 5-ыг үзнэ үү.

Санал: Санал асуулгаас гарсан хариултаар нэрлэхээс татгалзаж хасах саналтай байна.

2.2-2.4-ын хүрээнд:

Тайлбар: Засгийн газар, ХХААХҮЯ, ЖДҮГ, ЖДҮХС-ийн ажлыг 21 аймаг, нийслэлд хөнгөлөлттэй зээлд хамрагдсан болон хамрагдаагүй 1600 гаруй иргэн, аж ахуйн нэгжээс авсан 9 асуулттай санал асуулгын дүнгээр орон даяар хэрэгжсэн хөнгөлөлттэй зээлийн үр дүнг үнэлсэн нь тайлан өөрөө учир дутагдалтай байна.

2.5-2.6-ын хүрээнд:

Тайлбар: Орон нутагт ажиллаж байгаа дэд комиссын үйл ажиллагааны тухайд тайлагнаж байгааг тодотгож өгөх

2.7-ын хүрээнд:

Тайлбар: Арилжааны банк 100 хувь эрсдэл хүлээж буй тул аль болох банкуудын шалгуур үзүүлэлттэй ойр нөхцөл тавьж уян хатан байдлаар ажиллаж байгаа бөгөөд Төсвийн хөрөнгөөр олгож байгаа хөнгөлөлттэй зээлийн шалгуур үзүүлэлтийг зээл хүсэгчид хамгийн боломжит хэмжээнд хүртэл зохицуулж өгсөн болно.

2.8-ын хүрээнд:

Тайлбар: Шаардлага хангаагүй төслийг Дэд комисс банкуудад санал болгох эрхгүй бөгөөд шаардлага хангалаа гэж үзэж банкинд хүргэгдсэн иргэн, аж ахуйн нэгжүүд нь **өөрсдөө маш их хариуцлагагүй** ханддаг. Түүнчлэн банкинд очсон төслийнхөө талаар мэдэхгүй, төслөө тайлбарлаж хамгаалж чаддаггүй байдал их байна.

Энэ байдал нь төсвийн хөрөнгө эргэн төлөгдөхөд хүндрэлтэй тал үүсэх ба санхүүгийн хариуцлагын асуудал чухал болохыг анхаарна уу.

“Комиссын үйл ажиллагаа, сонгон шалгаруулалт шударга явагдахгүй байна” гарчигийн хүрээнд:

Тайлбар: Комиссын үйл ажиллагаа, сонгон шалгаруулалт шударга явагдахгүй байна гэж шууд санал асуулгаар дүгнэсэнтэй санал нийлэхгүй байна. Шударга бус үйл ажиллагаа явуулсан **тухайн аймгийн** талаарх мэдээллийг нотлох баримттайгаар тайландаа оруулж өгөх.

Санал: Гарчигийг **“Зарим аймгуудад байгуулагдсан төсөл сонгон шалгаруулах дэд комиссын төсөл сонгон шалгаруулах үйл ажиллагаа шударга явагдаагүй байна”** гэж өөрчлөх эсвэл хасах.

2.13-2.17-ын хүрээнд:

Тайлбар: Энэ талаар Ерөнхий сайд, Тэргүүн шадар сайд болон хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлж байсан.

ХХААХҮЯ, ЖДҮГ, ЖДҮХС-ийн ажилтнуудаас бүрдсэн ажлын хэсгүүд 2009 онд 2 удаагийн томилолтоор нийт 21 аймгийн 212 суманд хөнгөлөлттэй зээлд хамрагдсан 1095 иргэн, ААН-ын үйл ажиллагаанд мониторинг хийж ажилласан.

Санал: Энэ дүгнэлт нь зөвхөн иргэдээс авсан судалгааны дүнд гарсан нь учир дутагдалтай байгаа тул хасах саналтай байна.

Ерөнхий санал: Хоёрдугаар бүлгийн хүрээнд хийсэн дүгнэлтийг гаргахад ашигласан Санал асуулгын дүнг тусад нь хавсралт байдлаар оруулж өгөх саналтай байна.

Гуравдугаар бүлэг:

Бүлэг 3-ын гарчигийн агуулга:

Санал: **“Зээлийн хөрөнгийн хуваарилалт, зарцуулалт, сангийн үйл ажиллагаанд бүртгэлээр тавих хяналтын талаар”** гэж өөрчлөх.

3.14-ын хүрээнд:

**Тайлбар 6-г
үзнэ үү.**

**Тайлбар 7-г
үзнэ үү.**

**Тайлбар 8-ыг
үзнэ үү.**

**Тайлбар 9-ыг
үзнэ үү.**

Санал: Хөрөнгө банкуудад оройтож байршсан, Банкууд ТСШК-оос дэмжигдэж очсон төслийг судалж, шийдвэр гаргах хүртэл банкны дотоод журмын хүрээнд шийдвэрлэх шаардлага тулгардаг. Сангаас хөрөнгийг банкуудад байршуулсан тул бүрэн ашигласан тухай мэдээ гаргасан байна.

3.15-ын хүрээнд:

**Тайлбар 10-ыг
үзнэ үү.**

Санал: Бүс нутгийн эдийн засгийн хөгжлийг дэмжих чиглэлээр олгосон зээлийг тодруулж бичих.

3.16-ын хүрээнд:

**Тайлбар 11-ыг
үзнэ үү.**

Санал: Зээлийг зориулалтын дагуу ашиглаагүй зарим тохиолдлын талаар гэж өөрчлөх.

3.28-ын хүрээнд:

Тайлбар: ЖДҮГ, ЖДҮХС, банкны гаргаж өгсөн мэдээ 2009 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 5255 бөгөөд цаг хугацааны хувьд тоонд өөрчлөлт орж болно. Мэдээг хамтран ажиллаж байгаа банкуудаас зээлдэгч нэг бүрээр авч нэгтгэсэн байна.

**Тайлбар 12-ыг
үзнэ үү.**

Санал: Заалтыг хасах саналтай байна.

3.29-ын хүрээнд:

Тайлбар: Зөрүүтэй байгаа мэдээний талаар тодруулга хийсэн БӨ аймагт шинээр нэмэгдсэн ажлын байрны тоо ЖДҮХС-н мэдээгээр 150 биш 361 байгаа, СЭ аймагт 158 байгаа аймгийн банк баталдаг аймгийн аудитын газрын тоо аймгийн дэд комиссоос авсан, 2 аймгийн зөрүүтэй мэдээг тодотгож байгаа.

“ЖДҮХСангийн нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагнал, бүртгэлээр тавих хяналт хангалтгүй байна” гарчигийн агуулга:

**Тайлбар 13-ыг
үзнэ үү.**

Санал: “ЖДҮХС-ийн нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагнал, бүртгэлээр тавих хяналтын талаар” гэж өөрчлөх.

3.32 хүрээнд:

Тайлбар: Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан нь “Засгийн газрын тусгай сангийн тухай” хуулийн 27.1-д заасны дагуу Төрийн сангийн тусгай данс нээж улсын төсвөөс хуваарилсан хөрөнгө, эргэн төлөлтөөс орж ирсэн хөрөнгүүдийг байршуулж гүйлгээ хийсэн болно.

Санал: Дансуудын харилцан уялдааг ялгаж салгаж ажиллах, цаашид Төрийн сангаар дамжуулан бүх гүйлгээг хийдэг байхад анхаарч ажиллах.

3.34-ын хүрээнд:

Тайлбар: Улсын төсвөөс ЖДҮ хөгжүүлэх зорилгоор 2006-2008 онуудад жил бүр 1 тэрбум төгрөгийг хуваарилж ирсэн бөгөөд хуучнаар ҮХЯ-нь Хас, Зоос, Монгол шуудан банкуудаар дамжуулан хөнгөлөлттэй нөхцлөөр зээл олгосон байдаг.

2008 онд ЗГ-н шинэ бүтцээр ҮХЯ-ны харъяанд байсан ЖДҮХСан нь шинээр байгуулагдсан ХХААХҮЯ-ны харъяанд ирсэн.

2006-2008 онуудад хөнгөлөлттэй нөхцлөөр олгогдож байсан 2,9 тэрбум төгрөгийн эх үүсвэрийг ЖДҮХСангийн балансанд бүртгэх талаар албан ёсны шийдвэр ирээгүй тул эх үүсвэрийг 2009 оны жилийн эцэст ЖДҮХСангийн балансанд тусгаж тайландаа авлаа.

3.35-ын хүрээнд:

Тайлбар: 2,3 сая төгрөгийн авлагыг баталгаажуулаагүй нь номны авлага бөгөөд тухайн номыг борлуулах үед гарын үсэг зурж авсан баримт нь дүнгээрээ тулж байгаа юм.

Санал: Тайлбаруудыг бүтнээр оруулах эсвэл хасах.

Тайлбар: 88,9 сая төгрөгийн өглөгийн, 56,2 сая төгрөгийн үнэ бүхий номыг анх ХХААХҮЯамны ХҮБХЗГазараас 2009 оны 5 сард ЖДҮХСанд хүлээлгэн өгсөн. Номны үнэ бөгөөд тухайн үед хүлээлцсэн акт үйлдэж ЖДҮХСангийн нярав Я.Содсоёмбо авсан.

30 сая төгрөг нь тариалан эрхлэлтийг дэмжих сангаас зээлж ХХААХҮЯ-ны сургалтын байрны угсралтын хөлсөнд зарцуулсан. Үлдэх 3,7 сая төгрөг нь НДШ, ХАОАТ-ын өглөг юм.

Санал: Тайлбаруудыг бүтнээр оруулах эсвэл хасах.

Тайлбар: Бүх зээлдэгчид албан мэдэгдлийг Иргэний бүртгэлийн албанаас хаягийн тодруулга авч хүргүүлсэн. Монгол банкны өр барагдуулах албанаас мэдээлэл давхар авсан. Тэнд 7 зээлдэгчийн талаар мэдээлэл байсан бөгөөд бусад этгээдийн талаарх мэдээлэл гараагүй тул мэдээллийг устсан гэж үзэж байна.

Санал: Тайлбарыг дэлгэрэнгүйгээр оруулах.

Аудитын дүгнэлт хэсэгт:

Дүгнэлт 2-ыг хасах.

Тайлбар: ЖДҮХСантай адил төстэй үйл ажиллагаа хэрэгжүүлж буй сан /Жишээ нь: Тариалан эрхлэлтийг дэмжих сан/ - гууд нь мөн адил "Төрийн байгууллага, албан газар, улсын төсөвт үйлдвэрийн газар" статустай байгааг анхаарах.

Дүгнэлт 5-ыг өөрчлөн найруулах.

Санал: Төсөл сонгон шалгаруулах дэд комиссын бүрэлдэхүүн зарим аймгуудад оновчтой бус, сонгон шаогаруулсан зарим төсөл ЖДҮ-ийг хөгжүүлэх үндсэн чиглэл, зоригод нийцээгүй, орон нутгийн дэд комиссуудын хяналтын зөвлөл үүргээ гүйцэтгээгүй байна

Дүгнэлт 7-г хасах.

Тайлбар: Аймаг, нийслэлийн дэд комиссоос шийдвэрлэсэн төсөл болон банкуудаар дамжуулан олгогдсон төслийн зээлийн талаар нэгдсэн мэдээг 7 хоног, сар, улирал, хагас жилээр нэгтгэн гаргаж ирсэн. Мэдээг Сангийн удирдах зөвлөл, яамны холбогдох удирдлагуудад цаг тухайд нь танилцуулж, шаардлагатай мэдээ, мэдээлэл, тоо баримтаар хангаж ажиллаж ирсэн болохыг анхаарна уу.

Тайлбар 14-ийг үзнэ үү.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны саналд өгөх тайлбар:

Тайлбар 1

Иргэний хуулийн ерөнхий ангийн 26.1-д “Хуулийн этгээдийн иргэний эрх зүйн чадвар”-ийг тодорхойлохдоо Хуулийн этгээдийн эрх зүйн чадвар улсын бүртгэлд бүртгүүлснээр үүсэх тухай, мөн 33.2-т ашгийн бус хуулийн этгээдийг сан хэлбэрээр байгуулна гэж заасан. Мөн Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 5.1-д “Засгийн газрын тодорхой чиг үүрэг, зорилтыг санхүүжүүлэх зорилгоор улсын нэгдсэн төсвөөс төвлөрүүлсэн хөрөнгө, түүнчлэн уг арга хэмжээнд зориулан олгосон хандив, буцалтгүй тусламжийн орлогыг Засгийн газрын “Тусгай сан” гэх гэж заасан байхад ЖДҮХС улсын үйлдвэрийн газрын статустай байна. “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль”-ийн 15.1.3-т “Өөрт олгогдсон эд хөрөнгийн үндсэн дээр төсвийн хөрөнгөөр санхүүжилт авч болох бөгөөд зөвхөн төрийн хэрэгцээнд зориулсан үйлдвэрлэл, ажил, үйлчилгээ эрхэлдэг хуулийн этгээдийг улсын төсөвт үйлдвэрийн газар” гэж тодорхойлсон. Иймд саналыг хүлээн авах боломжгүй байна.

Тайлбар 2

Улсын Их Хурлын 2007 оны 52 дугаар тогтоол нь “Жижиг, дунд үйлдвэрийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” бие даасан тогтоол юм. Харин Улсын Их Хурлын 2007 оны 51 дүгээр тогтоолоор 2004 оны 14 дүгээр тогтоолын хавсралтад нэмэлт оруулсан байна. Иймд саналыг хүлээн авах боломжгүй байна.

Тайлбар 3

Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх зээлийг дамжуулан зээлдүүлэх арилжааны банкыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу сонгон шалгаруулах нь хуульд нийцэх тул тайланд өөрчлөлт оруулах шаардлагагүй гэж үзэж байна.

Тайлбар 4

Саналыг хүлээн авч “Төсөл сонгон шалгаруулах комиссын үйл ажиллагаа, хяналт хангалтгүй байна” гэж өөрчлөлт хийв.

Тайлбар 5

Бид санал асуулгыг 21 аймаг, нийслэлийн жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх зээлд хамрагдахаар хөөцөлдөж байсан, мөн зээлд хамрагдсан иргэдээс авсан бөгөөд энэ нь төслийн сонгон шалгаруулалт, зээл олгох үйл ажиллагаанд гарч буй нийтлэг дутагдал, шийдвэрлэвэл зохих асуудлыг харуулсан гэж үзэж байна.

Тайлбар 6

Тайлангийн 2 дугаар бүлгийн 2.2-2.4, 2.5-2.6, 2.7, 2.8, 2.11 дэх хэсэгт комиссын бүрэлдэхүүн болон сонгон шалгаруулах үйл ажиллагаанд гарсан нийтлэг доголдлыг жишээгээр харуулсан. Түүнчлэн орон нутагт үйлдвэрлэл хөгжүүлэх чиглэлийн хүрээнд эдийн засгийн хөгжилд нөлөө үзүүлэхүйц арга хэмжээнд сонгон шалгаруулсан төслийн талаар Худалдаа, хөгжил, Голомт банкнаас ирүүлсэн тайлбарт зээлийн шалгуур хангаагүй буцаагдсан нэр бүхий аж ахуйн нэгж банкаа

сольсон, төслөө шилжүүлсэн, өөр арилжааны банкнаас зээл авсан байна. Үүнийг сонгон шалгаруулах үйл ажиллагааг шаардлагын хэмжээнд зохион байгуулж явуулсан гэж үзэх боломжгүй юм. Иймд тайланд дэлгэрэнгүй өөрчлөлт хийх шаардлагагүй юм.

Тайлбар 7

Аудитын явцад авсан санал, асуулгын дүнг нэгтгэн хавсралтаар үзүүлсэн бөгөөд энэ нь хяналтын тухай асуудал юм. Өөрчлөлт хийх шаардлагагүй, мөн тайлангийн 2.9 дэх хэсгийг харна уу.

Тайлбар 8

Саналыг хүлээн авч бүлгийн дүгнэлтийг “ЖДҮХСангийн үйл ажиллагаанд бүртгэлээр тавих хяналт хангалтгүй байна” гэж өөрчлөв.

Тайлбар 9

Зарим зээл 2010 он гарч олгогдсон ба зөвхөн судлагдаж буй гэсэн шалтгаанаар өнгөрсөн онд байршуулсан эх үүсвэрээс 3.0 тэрбум гаруй төгрөг ашиглагдаагүй нь 24.0 илүү хувийг эзэлж байна. Иймд өөрчлөлт оруулах шаардлагагүй гэж үзлээ.

Тайлбар 10

Бүс нутгийн эдийн засгийн хөгжлийг дэмжих чиглэлээр олгосон зээлийг тайлангийн хавсралтаар үзүүлсэн тул дэлгэрэнгүй бичээгүй болно.

Тайлбар 11

Тайлангийн 3.26 дахь хэсгийн дэд гарчигийг “Зарим зээлдэгч зээлээ зориулалтын дагуу ашиглаагүй байна” гэж найруулгын өөрчлөлт хийв.

Тайлбар 12

Тайлангийн 3.28, 3.29-т Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэгч байгууллагуудын мэдээллийг хүлээн авах, тайлагнах, мэдээлэх тогтолцоог сайжруулах шаардлагатай байгаа нь аймгуудын тайлангаар нотлогдож байх тул өөрчлөлт хийх шаардлагагүй гэж үзлээ.

Тайлбар 13

Аудитын дүнд үндэслэн уг гарчгийг өгсөн бөгөөд харин тайлангийн 3.35 дахь хэсэгт тусгагдсан “1120.3 сая төгрөгийн найдваргүй авлагыг барагдуулаагүй байна” гэснийг “1120.3 сая төгрөгийн авлагыг шийдвэрлэх шаардлагатай байна” гэж өөрчлөв.

Тайлбар 14

Тайланд жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн үйл ажиллагааг хуульд нийцүүлэх, цаашид анхаарч, шийдвэрлэвэл зохих асуудлыг тусгасан тул агуулгын хувьд өөрчлөлт хийх шаардлагагүй байна.

Зөвлөмж:

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараахь арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтанд зөвлөж байна. Үүнд:

Монгол Улсын Ерөнхий сайд С.Батболдод:

- ЖДҮ-ийг хөгжүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр ажиллаж буй сангуудын үйл ажиллагааг нэгдсэн удирдлага, бодлогоор зохицуулах асуудлыг судалж, шийдвэрлэх,
- ЖДҮ эрхлэгчийн ангиллын талаар холбогдох хуульд өөрчлөлт оруулах асуудлыг судлан үзэж, зохих журмын дагуу шийдвэрлүүлэх,
- ЖДҮ-ийн тухай хуулийн 6 дугаар зүйлд заасны дагуу ЖДҮ эрхлэгчдийг бүртгэлжүүлэх ажлыг зохион байгуулах арга хэмжээ авах.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Т.Бадамжунайд:

- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу арилжааны банкуудыг сонгон шалгаруулж байх,
- ЖДҮТХуулийн 6 дугаар зүйлд заасны дагуу улсын бүртгэлд бүртгүүлсэн иргэн, аж ахуйн нэгжийг ЖДҮ-ийг дэмжих чиглэлээр олгох зээлд хамруулж байх,
- Төсөл сонгон шалгаруулах комиссын бүрэлдэхүүний сонголтыг оновчтой болгох, үйл ажиллагааны нээлттэй байдлыг хангуулах,
- Арилжааны банкуудтай байгуулсан хамтран ажиллах гэрээний дагуу хяналтын зардлыг төвлөрүүлэн авч байх,
- Арилжааны банкуудад байршуулсан ЖДҮХС-гийн дансыг хуулийн дагуу төрийн сангийн нэгдсэн дансны зохицуулалтад хамруулах,
- Зээл олголтод тавих хяналтыг сайжруулах, арилжааны банкинд ашиглагдаагүй эх үүсвэрийг татан төвлөрүүлэх, зориулалт бусаар ашиглаж буй зээлийг төлүүлэх талаар хамтран ажиллах гэрээнд өөрчлөлт оруулах асуудлыг судалж шийдвэрлэх,
- Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн нягтлан бодох бүртгэл, санхүүгийн үйл ажиллагаанд гарч буй зөрчил, дутагдлыг арилгах.

Хавсралтууд:

Хавсралт №1

ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭРЛЭЛИЙГ ДЭМЖИХ ЧИГЛЭЛЭЭР ОЛГОЖ БУЙ ЗЭЭЛ ОЛГОЛТЫН ТАЛААР
АВСАН САНАЛ АСУУЛГЫН НЭГТГЭЛ

№	Асуулт	Хариултын						
		хувилбар, Үүнээс:	тоо		хувь		тоо, бүгд	хувь
			Зээлд хам/сан	Зээлд хам/гүй	Зээлд хам/сан	Зээлд хам/гүй		
1	Төсөл сонгон шалгаруулах үйл ажиллагаанд тухай орон нутгийн удирдах албан тушаалтнуудын оролцоо, нөлөөлөл байдаг уу?	Тийм	208	497	31,7	48,0	705	41,6
		Үгүй	306	234	46,6	22,6	540	31,9
		Зарим талаар	143	305	21,8	29,4	448	26,5
2	Төсөл сонгон шалгаруулах комиссын бүрэлдэхүүн оновчтой сонгогдсон уу?	Тийм	336	183	51,1	17,7	519	30,7
		Үгүй	128	307	19,5	29,6	435	25,7
		Мэдэхгүй	193	546	29,4	52,7	739	43,7
3	Төсөл сонгон шалгаруулах комиссын үйл ажиллагаа олон нийтэд нээлттэй байж чаддаг уу?	Тийм	298	168	45,4	16,2	466	27,5
		Үгүй	210	662	32,0	63,9	872	51,5
		Мэдэхгүй	149	206	22,7	19,9	355	21,0
4	Төсөл сонгон шалгаруулах комиссын төслийн сонгон шалгаруулалтыг шударгаар явуулж чаддаг уу?	Тийм	340	185	51,9	17,9	525	31,1
		Үгүй	130	455	19,8	44,0	585	34,6
		Зарим талаар	185	395	28,2	38,2	580	34,3
5	Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих чиглэлээр зээл олж авахад хаана голлон бэрхшээл гарч байна вэ?	ТСШКомисс	136	352	21,3	34,0	488	29,2
		АБанк	433	639	67,7	61,8	1 072	64,0
		Зээл хүсэгч	71	43	11,1	4,2	114	6,8
6	Жижиг, дунд үйлдвэрлэлийн зээлийн шалгуур үзүүлэлт бодит нөхцөл байдалтай нийцэж байгаа юу?	Тийм	241	161	36,6	15,6	402	23,8
		Үгүй	116	344	17,6	33,3	460	27,2
		Өөрчлөх шаардлагатай	217	354	33,0	34,2	571	33,7
		Мэдэхгүй	84	175	12,8	16,9	259	15,3
7	Арилжааны банкууд шалгарсан төсөл, хөтөлбөрт зээл олгох үйл ажиллагаанд хүндрэл бэрхшээл гарч байна уу?	Тийм	274	350	41,8	33,8	624	36,9
		Үгүй	180	233	27,5	22,5	413	24,4
		Зарим талаар	201	453	30,7	43,7	654	38,7
8	Олгосон зээл орон нутагт жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд бодитой дэмжлэг болж чаддаг уу?	Тийм	425	318	64,8	30,7	743	43,9
		Үгүй	85	247	13,0	23,8	332	19,6
		Зарим талаар	146	471	22,3	45,5	617	36,5
9	Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих чиглэлээр одоогийн явуулж байгаа санхүүжилтийн хэлбэр, тогтолцоог цаашид үргэлжлүүлэх хэрэгтэй юу?	Шаардлагатай	558	699	85,2	67,5	1 257	74,4
		Шаардлагагүй	34	103	5,2	10,0	137	8,1
		Мэдэхгүй	63	233	9,6	22,5	296	17,5

Хавсралт №2

ЗЭЭЛ ОЛГОЛТ БА ЭРГЭН ТӨЛӨЛТ, ХУГАЦААНЫ СУДАЛГАА /мян.төг/

№	Банк	Аймаг, нийслэл	Зээлийн хэмжээ /мян.төг/, Үүнээс:			Зээл эргэн төлөгдөх ерөнхий хугацаа /календарын хоног/		
			Олгосон	Төлсөн	Үлдэгдэл	Дундаж	Их	Бага
1	Зоос банк	Архангай	845 000,0	6 553,5	838 446,5	1 050	1 096	91
2		Баян-Өлгий	763 000,0	45 537,2	717 462,8	1 087	1 096	365
3		Дорнод	604 180,0	12 074,3	592 105,7	1 016	1 096	365
4		Ховд	782 000,0	19 371,5	762 628,5	1 096	1 096	1 096
5		Хөвсгөл	745 600,0	13 713,8	731 886,2	1 072	1 096	730
6		Сэлэнгэ	727 600,0	2 843,7	724 756,3	1 089	1 096	730
7		Нийслэлд	180 000,0	17 998,9	162 001,1	936	1 096	549
Дүн			4 647 380,0	118 092,9	4 529 287,1			
8	Монгол Шуудан	Орхон	780 000,0	64 928,0	715 072,0	886	1 004	365
9		Завхан	780 000,0	11 985,0	768 015,0	965	1 096	730
10		Өвөрхангай	771 600,0	25 818,0	745 782,0	857	943	350
11		Дундговь	735 758,0	52 985,8	682 772,2	921	994	185
12		Говь-Алтай	801 690,0	45 287,0	756 403,0	830	974	365
13		Сүхбаатар	780 000,0	30 604,0	749 396,0	933	1 004	395
14		Дорноговь	783 850,0	50 945,0	732 905,0	936	999	365
15		Нийслэлд	299 000,0	12 918,0	286 082,0	783	972	365
Дүн			5 731 898,0	295 470,8	5 436 427,2			
16	Хас банк	Баянхонгор	778 050,0	43 620,8	734 429,2	826	1 107	704
17		Өмнөговь	645 971,1	30 586,1	615 385,0	940	1 111	303
18		Булган	807 993,6	46 119,0	761 874,6	974	1 113	586
19		Төв	906 620,1	36 819,4	869 800,7	992	1 115	364
20		Увс	828 400,0	20 137,6	808 262,4	902	1 108	302
21		Хэнтий	716 100,0	46 822,3	669 277,7	840	1 107	450
22		Дархан-Уул	763 250,0	15 675,0	747 575,0	912	1 105	631
23		Говьсүмбэр	737 650,0	34 628,1	703 021,9	997	1 107	718
24		Өвөрхангай	36 861,7	1 126,1	35 735,6	659	732	335
25		Нийслэлд	234 000,0	15 740,3	218 259,7	859	1 101	720
Дүн			6 454 896,5	291 274,7	6 163 621,8			
26	УБ	Нийслэлд	6 266 650,0		6 266 650,0	649	1 097	7
27	Кап	Нийслэлд	2 688 530,0	91 827,7	2 596 702,3	985	1 096	242
Бүгд			25 789 354,5	796 666,1	24 992 688,4	926	1 115	7



МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОРЫН ТУШААЛ

2010 оны 04 сарын 01 өдөр

Дугаар 41

Улаанбаатар хот

Аудитын тайланг баталгаажуулах тухай

“Төрийн аудитын тухай хууль”-ийн 13.4.5, “Гүйцэтгэлийн шалгалтын журам”-ын 23.2, “Гүйцэтгэлийн аудитын тайланг хянан баталгаажуулах журам”-ын 4.2-т заасныг үндэслэн ТУШААХ нь:

Нэг.Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих чиглэлээр 2009 онд улсын төсвөөс олгосон хөрөнгийн зарцуулалт, зээлийн ашиглалтад хийсэн аудитын тайланг баталсугай.

Хоёр.Аудитаар илэрсэн төлбөр, зөрчлийн жагсаалтыг 1 дүгээр хавсралтаар баталсугай.

Гурав.Аудитын тайланг Улсын Их Хурлын Төсвийн Байнгын хороо, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Жижиг, дунд үйлдвэрийн газар, Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх санд хүргүүлсүгэй.

Дөрөв.Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, үр дүнг 2010 оны 10 дугаар сарын 1-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Т.Бадамжунайд зөвлөсүгэй.

Тав.Аудитын тайланд тусгагдсан зөрчлийн барагдуулалт, зөвлөмж, төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг Удирдлагын зөвлөлд танилцуулж ажиллахыг Үндэсний аудитын газрын Гүйцэтгэлийн аудитын газрын захирал Д.Ганбилэгт үүрэг болгосугай.



Цераг

Ч.РАДНАА

070051

Монгол Улсын Ерөнхий аудиторын
2010 оны 04 дугаар сарын 04-ний 11 дугаар
тушаалын 1 дүгээр хавсралт

Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих чиглэлээр 2009 онд улсын төсвөөс олгосон
хөрөнгийн зарцуулалт, зээлийн ашиглалтад хийсэн гүйцэтгэлийн
аудитаар илрүүлсэн төлбөр, зөрчлийн жагсаалт

(сая төгрөгөөр)

Д/д	Төлбөр хариуцагчийн		Төлбөр, зөрчлийн товч агуулга	Төлбөрийн дүн	Зөрчлийн дүн
	Нэр	Албан тушаал			
1	М.Баярмагнай Ц.Цэдэндаш	ЖДҮХС-ийн захирал ЖДҮХС-ийн нягтлан бодогч	Хяналтын зардлыг төвлөрүүлэн авах тухай	177.8	
2	Т.Бадамжунай	ХХААХҮ-ийн сайд	Хуулийн хэрэгжилтийг хангуулах, зөрчлийг арилгуулах тухай		1,211.5
Дүн				177.8	1,211.5

ОРОН НУТАГТ ҮЙЛДВЭР ХӨГЖҮҮЛЭХ ЧИГЛЭЛИЙН ХҮРЭЭНД СОНГОН ШАЛГАРУУЛЖ ДЭМЖИГДСЭН ТӨСӨЛ, 2009 ОНЫ ЗЭЭЛ ОЛГОЛТЫН БАЙДАЛ

Д.д	Төсөл дэмжигдсэн ЖДҮ эрхлэгчийн нэр	Жижи, дунд үйлдвэрлэл эрхлэх бизнес						Олгосон зээлийн					Тайлбар		
		төслийн нэр	ЖДҮДС-д ирүүлсэн огноо	ТӨСЛИЙН ХЭМЖЭЭ	ТСШК-ын хурлаар			огноо	телех огноо	хүү /хувиар/	Зориулалт	нийт хэмжээ, Үүнээс:			
					хэлэлцүүлсэн огноо	дэмжиж шийдвэрлэсэн хэмжээ	Сангаас шилжүүлсэн эх үүсвэр					Эх үүсвэр шилжүүлсэн огноо		Сангийн эх үүсвэрээс	АБ-ны эх үүсвэрээс
А	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	
Улаанбаатар хотын банк															
1	Бат-Өрнөд ХХК	Сүү-мажны чиглэлийн үхрийн ферм	09.05.18	283,0	09.06.23	100,0	80,0	09.09.11	09.09.16	14.09.16	0,8	Фермерийн аж ахуй	80,0	20,0	
2	Нэхий Агр ХХК	Сүү үхрийн эрчимжсэн аж ахуй	09.06.10	185,0	09.06.23	100,0	80,0	09.10.09	09.10.14	14.07.14	0,8	Саалийн үнээ, мажны чиглэлийн үхрийн фермийн байр байгуулах,	80,0	20,0	
Дүн				468,0		200,0	160,0						160,0	40,0	
Худалдаа хөгжлийн банк															
1	Таван трейд ХХК	Автоклавын хөнгөн бетоны үйлдвэрийг өргөтгөх	09.07.09	250,0	09.07.10	100,0	80,0	09.09.18	09.09.24	14.09.24	0,8	Барилгын ханын дүүргэгч хөнгөн бетон үйлдвэрлэх	80,0	20,0	09/11/17-нд 20.0 сая төгрөг олгосон
2	Замбатив ХХК	Шимт тэжээл мал, амьтаны тэжээлийн үйлдвэр байгуулах	09.04.15	300,0	09.07.10	100,0	80,0	09.09.18	09.10.01	14.10.01	0,8	Бод, бог мал гахайд шаардлагатай уураг, тос, нүүрс тэжээл үйлдвэрлэх	80,0	10,0	10/01/11-нд 5.0 сая төгрөг нэмж олгосон
3	Гацуурт ХХК	10000 тн хүнсний ногооны зоорь	09.06.17	4.000,0	09.06.23	1.000,0	800,0	09.09.18	09.09.21	14.09.21	0,8	10000 тн хүнсний зоорь барьж, төмс, х/ног хад-х	800,0	200,0	09/12/31-нээс өмнө 200.0 сая төгрөг зээл төлсөн.
4	Баян дулаан уул ХХК	Мах боловсруулах, ангилах үйлдвэр	09.06.15	3.200,0	09.06.23	1.000,0	800,0	09.09.18	09.09.21	14.09.21	0,8	мах ангилан савлах үйлдвэр	800,0	200,0	09/12/31-нээс өмнө 200.0 сая төгрөг зээл төлсөн.
5	Агробулган ХХК	Сүү-мажны чиглэлийн үхрийн ферм	09.07.09	100,0	09.10.21	90,0	72,0	09.09.18	09.10.01	14.10.01	0,8	сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	72,0	18,0	
6	Эм-Пи-Ай консталинг-Монгол түлхүүр ХХК	Хонины ноосор барилгын дулаалгын материал үйлдвэрлэх	09.07.29	900,0	09.06.23	400,0	320,0	09.10.26	09.12.23	14.11.17	0,8	Үйлдвэрийн тоног төхөөрөмж худалдан авах	320,0		
7	Монжимо ХХК	Ургамал хамгаалалтын бодис үйлдвэрлэх цех байгуулах, давхар баяжуулсан давсны цех	09.06.08	359,2	09.06.23	300,0	240,0	09.10.09	09.10.13	14.10.13	0,8	Эмийн үйлдвэрлэл	240,0	10,0	
8	Азийн говь ХХК	Хөнгөн бетон үйлдвэрлэл	09.05.21	300,0	09.10.21	300,0	240,0	09.11.18	09.12.18	14.11.20	0,8	бетон үйлдвэрлэл	240,0	60,0	
9	Хайрхан үр тариа ХХК	Газар тариалангийн үйлдвэр түшиглэсэн эрчимжсэн фермерийн аж ахуй байгуулах	09.07.24	182,0	09.10.21	180,0	144,0	09.12.22				газар тариалан үйлдвэрлэл			10/01/18-нд 69.9 сая төгрөг 10/02/02-нд 69.9 сая төгрөг 10/02/09-нд 69.9 сая төгрөг
10	Сан бэйс ХХК	Сүүний үйлдвэрийг өргөтгөх	09.07.08	50,0	09.07.10	50,0	40,0	09.09.18	09.09.29	14.09.24	0,8	Сүү боловсруулах	40,0	10,0	
11	СХЦБ ХХК	Чацаргана боловсруулах үйлдвэр	09.06.28	80,0	09.07.10	80,0	64,0	09.09.18	09.09.18	14.09.18	0,8	Жимс, химсгэнэ, чацарганы аж ахуйг хөгжүүлэх, суулгац үржүүлэх	54,5		10/01/18-нд 25.5 сая төгрөг олгогдсон
Дүн				9.721,2		3.600,0	2.880,0						2.726,5	528,0	
Үндэсний хөрөнгө оруулалтын банк															
1	Цэст Хайрхан ХХК	Чацаргана боловсруулах үйлдвэр	09.05.18	1.000,0	09.06.23	400,0	320,0	09.10.09				Тоног төхөөрөмж худалдан авах			Зээл олгодоогүй, судлагдаж байгаа
2	Агро тех ХХК	Төмс хүнсний ногооны зоорь	09.06.19	1.200,0	09.06.23	1.000,0	800,0	09.10.09				10000 тн хүнсний ногооны зоорь барих			Зээл олгодоогүй, судлагдаж байгаа
3	Монфрукт ХХК	Бүрэн автомат хүлэмжийн аж ахуй	09.06.25	753,0	09.07.10	300,0	240,0	09.10.09				4 улирлын халаалттай 10 га галбайд хүлэмж барих			Зээл олгодоогүй, судлагдаж байгаа
4	Эс би холдинг ХХК	Даршилсан хүнсний ногооны үйлдвэр	09.06.25	500,0	09.07.10	400,0	320,0	09.10.09				Сайн тех/технологи бүхий стандарт өндөр түвшний даршилсан ногооны үйлдвэр байгуулах			Зээл олгодоогүй, судлагдаж байгаа
5	Дээд Өнгө ХХК	Made in Mongolia	09.03.31	800,0	09.06.23	800,0	640,0	09.10.09	09.12.24	14.12.21	0,8	Оёмол сүлжмэл бүтээгдэхүүн үйлдвэрлэх	180,0		10/01/06-нд 220.0 сая төгрөг олгогдсон
6	Их Бодонч ХХК	Мах боловсруулах үйлдвэр	09.09.03	400,0	09.10.21	400,0						Мах махан бүтээгдэхүүн үйлдвэрлэл			10/01/20-нд 120.0 сая төгрөг олгогдсон
7	Висдомс эссетс холдингс ХХК	GMPB GIP олон улсын стандарттай биотехнологийн үйлдвэрийн бизнес төлөвлөгөө	09.06.25	1.383,4	09.07.10	600,0	480,0	09.10.09	09.11.06	11.10.30	1,0	Зурх судас, хорт хавдар, урвасл болон дархлааны өвчнийг анагаадаг 6 төрлийн бүтээгдэнүүн үйлдвэрлэнэ.	480,0	112,1	09/11/06-наас эхлэн зээлийг хэсэгчлэн олгосон. Банкны эх үүсвэрийг 20 хувиар тооцон харуулав.
Дүн				6.036,4		3.900,0	2.800,0						660,0	112,1	

Монгол шуудан, Хадгаламж банк															
1	Хадат өндөр өгөөж ХХК	Цементийн үйлдвэр	09.06.09	2,629,0	09.06.23	1,000,0	800,0	09.10.09				эргэлтийн хөрөнгө			Зээл олгогдоогүй, судлагдаж байгаа
2	HDP ХХК	Бетон зуурмаг	09.06.01	712,5	09.06.23	400,0	320,0	09.10.09	09.12.23			Дүүргэлт бетон буюу суурь ханын зуурмаг үйлдвэрлэх	320,0	80,0	
3	Чамон ХХК	Чацаргана боловсруулах үйлдвэр	09.09.09	1,900,0	09.06.23	600,0	480,0	09.12.16				Чацаргана тариалах			Зээл олгогдоогүй, судлагдаж байгаа
4	Натур Фүүд ХХК	Нарийн ногоо тариалах	09.06.22	600,0	09.06.23	400,0	320,0	09.10.09	09.12.16	14.12.16	0,8	Төмс хүнсний ногоо тариалах	200,0		
5	Болор цэвэр ус ХХК	Ориент пластик цогцолбор үйлдвэр	09.03.26	1,000,0	09.06.23	400,0	320,0	09.12.16	09.12.18	14.12.18	0,8	Болор ус шүүгчийн шүүлтүүр, ээлжийн шүүгч, сантехникийн хуванцар холбогчуудыг үйлдвэрлэх	87,0		10/01/06-нд 57.0 сая төгрөг олгосон, гүйцэтгэлээр олгогдож байгаа
6	Баярск констракшн ХХК	Агробордоо агрошүүлтүүр үйлдвэрлэх төсөл	09.06.19	1,215,5	09.07.10	400,0	320,0	09.10.30	09.11.27	14.11.27	0,8	Агробордоо, агрошүүлтүүр үйлдвэрлэх	320,0	80,0	
7	Илч ХХК	Гачууртын СТУМ цогцолбор	09.06.22	116,0	09.06.23	100,0	80,0	09.11.18				Сүү-тэжээл-улаанбуудай-махыг бэлчээрийн байдлаар бэлтгэдэг хэлбэрийг орчин үеийн үйлдвэрлэлийн эрчимжсэн технологи, инноваци нэвтрүүлэхэд шилжүүлэхэд зориулах			Зээл олгогдоогүй, судлагдаж байгаа
8	Петродел ХХК	Зах хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, Өлзийт хор-лолд цогц үйлчилгээний төв байгуулах төсөл	09.09.07	250,0	09.10.21	250,0	200,0	09.11.18				Жилд 5000 зочид, 120,000 иргэдийг хүлээн авч үйлчлэх үйлчилгээний байгууллага байгуулах.			10/01/05-нд 79.0, 10/01/18-нд 39.0, 10/01/29-нд 54.2, 10/02/12-нд 77.8 сая төгрөг тус тус олгосон.
9	Түмэн шувуут ХХК	Шувууны аж ахуй хөгжүүлэх	09.06.29	500,0	09.07.10	200,0	160,0	09.10.30	09.11.27	14.11.27	0,8	Үржлийн өндөг худалдан авна. 125000 ш үржлийн өндөгөөс дэгдээхэй гаргаж авна.	160,0	40,0	
Дүн				8,923,0		3,750,0	3,000,0						1,087,0	200,0	
Голомт															
1	Само институт ХХК	Бог нядлан боловсруулах үйлдвэр	09.06.15	2,000,0	09.06.23	1,000,0	800,0	09.09.18	09.12.01	14.12.01	0,8	Мах ангилах савлах.	800,0	200,0	
2	Ораметалл ХХК	Тээрмийн бөмбөлөгийн үйлдвэр	09.05.18	852,0	09.06.23	600,0	480,0	09.10.26				Ган бөмбөлөгийн үйлдвэр барих			2010/02/09-нд олгогдсон
3	Мик Маркет ХХК	Мах боловсруулах үйлдвэр, ангилах үйлдвэр	09.07.08	1,000,0	09.10.21	400,0	320,0	09.12.16				Мах махан бүтээгдэнүүн үйлдвэрлэл			ЗХ-ны шийдвэр 2009/12/11-нд гарсан, хүлээгдэж байна
4	Жарахайн булаг ХХК	Арматурын төмөр цувах үйлдвэр	09.06.17	239,0	09.07.10	70,0	56,0	09.11.06	09.11.17	12.11.17	0,8	Ган ширэм хайлуулах цутгуурын үйлдвэрийг өргөтгөх арматурын болон металл хийцийг цувах	56,0	14,0	Шилжүүлсэн 56.0 сая төг-н эх үүсвэрийг 09/11/13-нд татсан байна.
5	Арвис консалтинг ХХК	Нийлэг шүүдэйн үйлдвэр	09.06.11	250,0	09.06.23	100,0	80,0	09.10.26	09.10.19	14.10.19	0,8	Шуудай өөж нийлүүлэх.	70,0		Гүйцэтгэлээр олгож байгаа
Дүн				4,341,0		2,170,0	1,736,0						926,0	214,0	
Капитрон															
1	Хар хорин ХХК	Чацаргана боловсруулах үйлдвэр	09.06.16	400,0	09.10.21	400,0	320,0	09.12.16	09.12.30	10.01.05	0,8	Газар тариалан үйлдвэрлэл	200,0		10/01/29-нд 100.0 сая төгрөг олгогдсон
2	Шарын гол энерго ХХК	Нүүрс гүн боловсруулж, утаагүй коксон тулш үйлдвэрлэх цэвэр эрчим хүчний төсөл	09.06.16	2,151,7	09.07.10	350,0	280,0	09.11.02	09.11.06	14.11.04	0,8	Нүүрсийг дулааны аргаар боловсруулан коксжсон нүүрс үйлдвэрлэх	188,5		10/01/04-нд 28.5 с/т олгосон 10/02/01-нд 30.2 с/т олгосон 10/02/02-нд 25.8 с/т олгосон
Дүн				2,551,7		750,0	600,0						388,5	-	
ХААН															
1	Адилет ХХК	Гурил 2009 үйлдвэрийн төсөл	09.02.03	450,0	09.06.23	400,0	320,0	09.12.12	09.12.10	13.01.07	0,8	Баруун бүсийн гурилын хэрэгцээг хангаж гурил үйлдвэрлэх	320,0	80,0	Баян-Өлгийд
Дүн				450,0		400,0	320,0						320,0	80,0	
Зоос банк, Гөрийн банк/															
1	Монгол Алтан Тос ХХК	Ургамлын тос майонезны үйлдвэр	09.06.09	2,000,0	09.06.23	1,000,0	800,0	09.11.06	09.11.06			түүхий тос худалдан авч, ургамлын тос үйлдвэрлэн гаргах	120,0		Эх үүсвэрээс 680.0 сая төгрөгийг 2010.01.12-нд татсан, Зээл нь Зоос банкинд, эх үүсвэр нь Төрийн банкинд байршсан.
Дүн				2,000,0		1,000,0	800,0						120,0	-	
38	БҮГД ДҮН			34,491,3		15,770,0	12,296,0						6,388,0	1,174,1	